

ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГАРГАЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ
ЭРХИЙН АСУУДАЛ



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГАРГАЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ
ЭРХИЙН АСУУДАЛ**

Улаанбаатар
2022

ННА 67.401
ДАА 342
С-825



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
ГАРГАЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ ЭРХИЙН АСУУДАЛ

СУДАЛГААНЫ БАГ:

Судлаач Д.Сүнжид, Хууль зүйн доктор (Dr.Jur)

Судлаач Б.Төрболд, “Оюуны-Инноваци” ТББ-ын судлаач, хуульч

Судлаач Н.Оюун-Эрдэнэ, Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч

© Нээлттэй Нийгэм Форум, 2022

Хаяг: Жамьян гүний гудамж

Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар 14240

Утас: 976-73113207

Веб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9840-7-6

АГУУЛГА

Удиртгал.....	7
Нэг. Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрх.....	11
Хоёр. Иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх төрийн байгууллага, албан тушаалтны үүрэг.....	18
Гурав. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт, иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэх процесс, практикт үүсэж буй тулгамдсан асуудал.....	44
Дөрөв. ЗЕХ-д тусгахаар боловсруулсан нэмэлт, өөрчлөлт нь өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхийг ханган баталгаажуулах байдал.....	53
Дүгнэлт.....	58
Хавсралт 1. Олон улсын туршлага.....	61
Хавсралт 2. Анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэрүүдийн жагсаалт....	70

ӨМНӨХ ҮГ

Ардчилсан нийгэмд иргэд засаглалд оролцох нэг хэлбэр нь төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх явдал байдаг. Монгол Улс Үндсэн хуулийнхаа Арван зургадаар зүйлийн 12 дахь хэсэгт иргэдийнхээ төрийн үйл хэрэгт ийнхүү оролцох эрхийг тусган баталгаажуулсны дээр 1995 онд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг баталсан нь өнөөг хүртэл үйлчилж байна. Энэ хугацаанд тасралтгүй үргэлжилж ирсэн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд гарсан нэг томоохон өөрчлөлт нь Захиргааны ерөнхий хууль юм. Хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн 2016 оноос хойш захиргааны суурь харилцааг бүхэлд нь нэгтгэн зохицуулах болсон уг хуульд өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл явцыг нэг мөр ойлгомжтой болгох нэмэлт, өөрчлөлт оруулахаар хууль тогтоох байгууллага хэлэлцэж эхлээд байна. Үүнтэй уялдуулан Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (ИТБАТГӨГШтХ)-ийг хүчингүй болгох асуудал мөн яригдаж буй юм. Энэхүү өөрчлөлт нь Үндсэн хуулиар баталгаажсан дээрх эрхийг хэрэгжүүлэхэд ямар нөлөө үзүүлэх, аливаа хийдэл үүсгэх эсэх талаар тодруулах зорилгоор хийгдсэн “Захиргааны ерөнхий хуулийн шинэчлэл: төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхийн асуудал” судалгааны үр дүнг Та бүхэнд толилуулж буйдаа таатай байна. Иргэний үндсэн эрхтэй холбоотой аливаа хуулийг шинэчлэхэд тухайн эрхийн баталгааг дордуулахгүй байх нь нэн тэргүүнд баримтлах зарчим билээ.

Судлаачид иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг бүхэлд нь авч үзэн, гол хуулиудыг харьцуулан дүн шинжилгээ хийсний зэрэгцээ иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэх харилцаанд тулгамдаж буй асуудал, шалтгааныг тодруулах зорилгоор холбогдох шүүхийн шийдвэрүүдийг мөн судалжээ. Судалгааны дүгнэлтэд дурдсанаар Захиргааны ерөнхий хуульд тусгахаар боловсруулсан нэмэлт өөрчлөлт нь иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үйл явцыг хурдан шуурхай, хүнд суртал багатай болгоход чиглэсэн байгаа нь сайшаалтай боловч уг нэмэлт өөрчлөлтийн хүрээнд ИТБАТГӨГШтХ-ийг хүчингүй болгох аваас Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэлд хамаарахгүй төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг

шийдвэрлэх процесс орхигдож байгааг анхааруулжээ. Тухайлбал, Улсын Их Хурал, түүний Байнгын, дэд, түр хороод, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлэх асуудлыг ИТБАТГӨГШТХ-ийн дагуу зохицуулж байгаа бөгөөд хууль хүчингүй болсон тохиолдолд хийдэл үүсэхээр байгааг сануулсан байна.

Та бүхэн энэхүү судалгааны тайланг манай байгууллагын www.forum.mn цахим хуудаснаас авч үзэх боломжтой. Судалгааны тайлантай холбоотой санал бодлоо хуваалцах аваас бид талархан хүлээж авах болно.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд Захиргааны ерөнхий хууль (ЗЕХ)-ийг баталсан нь 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Уг хууль нь Монгол Улсад анх удаа захиргааны суурь харилцааг бүхэлд нь нэгтгэн зохицуулснаараа эрх зүйн хөгжилд болон захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, иргэдийн оролцоог хангадаг болгоход чухал түлхэц болсон юм. ЗЕХ хэрэгжиж эхэлснээс хойш хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд зарим саад бэрхшээл тулгарч байгаатай холбоотой цаашид хуулийг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэн, улмаар 2018 онд “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” сэдэвт судалгаа¹ хийжээ. Уг судалгааны зөвлөмжид иргэдийн оролцооны уламжлалт хэлбэр болох төрийн байгууллагад өргөдөл, гомдол гарган шийдвэрлүүлэх асуудлаар тодорхой санал туссан байна.

Тодруулбал, ЗЕХ батлагдахад мөн хуулийн 9 дүгээр бүлэгт “Гомдол шийдвэрлэх журам”-ын талаарх тодорхой зохицуулалт туссан. Үүнээс өмнө 1995 онд Монгол Улсын Их Хурал Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (ИТБАТГӨГШТХ) батлан гаргаж, уг хуулиар иргэдийн зүгээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг зохицуулж ирсэн. ЗЕХ батлахад ИТБАТГӨГШТХ-ийг хүчингүй болгоогүйгээс хууль хоорондын давхардал, зөрчил үүсэн, ЗЕХ-ийн холбогдох бүлгийг хэрэглэх боломжгүй байдал үүссэн талаар дээрх судалгаанд дурджээ.

¹ Хууль зүй, дотоод хэргийн яам, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” судалгаа, 2018.

Монгол Улсын Засгийн газраас Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан 2021 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.² Нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх харилцааг зохицуулахад гарч буй хуулийн давхардлыг арилгах, 1995 онд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг хүчингүй болгох саналыг хэлэлцэж байна. Энэхүү төслийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, 2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр³ чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулан үзэл баримтлалын

² Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн бүрдлийг <http://forum.parliament.mn/projects/11017> эндээс үзэх боломжтой.

³ Улсын Их Хурлын 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх тухай хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар “Гол нь иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах энэ журмын тухай, түүнийг шийдвэрлэх журмын тухай хууль 25 жил хэрэгжсэн. Иргэдийн ганц барьж явдаг хууль маань энэ шүү дээ. Үүнийг Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулаад хүчингүй болгох гээд байгаа юм. Бие даасан хуулиар шийддэг байсан юмыг хуулийн нэг бүлэг болгож шийдэх гээд байна л даа. Тэгээд Захиргааны ерөнхий хуулийн тэр бүлэгтэй давхцаж байгаа бол бие даасан хуулиа сайжруулаад энэ бүлгээ хасаад явчхаж болно шүү дээ. Тийм учраас энэ бие даасан хуулиар хүний эрхийг хангах нь зүйтэй гэж би үзэж байгаа юм. Ийм учраас энэ асуудлыг хойшлуулаад бие даасан хуулийг Хууль зүйн яам, хууль санаачлагчид маань оруулаад ирэх боломжтой. Уг асуудалдаа саяын яриад байгаа процессжуулах, дэвшилтэт өргөдөл, гомдлыг шийдвэрлэдэг энэ механизмуудаа хангаад оруулаад ир. Тэгээд явах юм бол Улсын Их Хурал дэмжихэд бэлэн байгаа гэж бодож байна” гэсэн горимын санал гаргасан байдаг. Гэвч горимын санал дэмжигдээгүй.

хүрээнд дэмжсэнээр⁴ Хууль зүйн байнгын хороо⁵ анхны хэлэлцүүлэг хийгээд байна.⁶

Иймд судалгааны багийн зүгээс:

- Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид туссан өргөдөл, гомдол гаргах эрхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг харьцуулах, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж байгаа процессыг судлах;
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт, иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэх процесс, практикт тулгамдаж буй асуудал, шалтгаан, цаашдын шийдлийн хувилбар, үр дагаврыг тодорхойлох, мөн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх;

⁴ Харин Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар: “Тэр өргөдөл, гомдлын асуудал бол тэр хуулийг хүчингүй болгох нь зөв өө. Энэ чинь тэр ганцхан захиргааны байгууллагууд биш шүү дээ. Парламентын захиргаа гэдэг чинь Тамгын газрын асуудал орохоор энэ өргөдөл, гомдол чинь захиргааныхаа ерөнхий хууль, удирдлагын процесс гэдэг энэ хуулийн үйлчлэлд хамаарч байгаа байхгүй юу. Шүүх дээр ч байна уу, Ерөнхийлөгч дээр ч байна уу, энэ бүх захиргаа чинь, захиргааны үйл ажиллагаа чинь захиргааны акт явагдаж байгаа. Тэгэхээр энд тийм Үндсэн хуульд заасан асуудал дээр асуудал үүсэхгүй. Харин ч энэ хуулийн хүрээнд орсноор бүх юм ном журамдаа орж байгаа юм шүү. Үүнийг би одоо бас захиргааны эрх зүйн мэргэжлийн хүний хувьд хэлэхэд иргэдээс өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажиллагаа гэдэг бол захиргааны процесс ажиллагааны нэг хэсэг юм шүү. Үүнийг бол одоо бас санаа зовж хэрэггүй. Зүгээр дотор нь энэ хуулийг хэлэлцсэний дараа янзлах сайжруулах юм бол бий. Энэ бол зөв чиглэлд явж байгаа юм шүү” гэсэн. Хуралдааны тэмдэглэлийг эндээс үзэх. <http://www.parliament.mn/files/123080>

⁵ Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ <http://www.parliament.mn/n/qyzyn>

⁶ Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 02 дугаар тогтоолоор Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Б.Энх-Амгалан нар болон ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох байгууллагын албан тушаалтнууд ажиллаж байна.

- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг хүчингүй болгох хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тодорхойлох;
- Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагааны талаарх гадаад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийхийг зорьсон болно.

Судалгаа хийж гүйцэтгэсэн арга зүй, зохион байгуулалт

Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ юуны түрүүнд иргэний хувьд төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхийн хүрээг тодорхойлохыг зорьж, улмаар уг эрхийг баталгаатай эдлүүлэх, хэрэгжилтийг нь хангах процессыг зохицуулсан хууль тогтоомж, холбогдох бичмэл эх сурвалжид дүн шинжилгээ хийсэн ба өргөдөл, гомдол шийдвэрлэхтэй холбоотой практикт тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг тодорхойлохын тулд ярилцлагын аргаар эрдэмтэн, судлаачдын саналыг авсан. Түүнчлэн бусад улс орны туршлагыг харьцуулан нэмэлт эх сурвалж болгон ашиглав.

Судалгааг (i) баримт бичгийн судалгаа; (ii) иргэний өргөдөл, гомдол гаргах эрхийн талаар мэдээлэл цуглуулах; (iii) гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалтыг судлах; (iv) судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, дүгнэлт өгөх гэсэн дөрвөн үе шатаар гүйцэтгэв.

НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГАРГАЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ ЭРХ

Төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх нь иргэний үндсэн эрх, иргэний оролцооны уламжлалт хэлбэр юм. Нийгмийн амьдралд идэвхтэй оролцон, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, алдаа дутагдал, зөрчил гажуудлыг нь арилгах хэлбэрээр өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх иргэний эрх хэрэгждэг.⁷ Энэхүү эрхийг хуулиар хамгаалан баталгаажуулах нь иргэд өөртөө болон нийгмийн бүлэг, нэгж, нийтэд тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх, шийдвэр гаргахаас өмнө олон талт хүчин зүйлийг судлах боломж бүрдүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг залруулах, алдаа гарахаас урьдчилан сэргийлэх, хууль ёсны зарчмыг сахиулахад чухал ач холбогдолтой. Өргөдөл, гомдол гаргагчийн эрх, түүнийг хамгаалах тогтолцоо Монгол Улсын 1940, 1960 оны Үндсэн хуульд тусгагдаагүй байсан бөгөөд харин 1992 оны Үндсэн хуульд тусгалаа олсноор хүний эрхийг захиргааны эрх зүйгээр бодитой хамгаалах суурь тавигджээ.⁸

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гээд уг зүйлийн 12 дахь хэсэгт “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” хэмээн заасан. Энэхүү заалтын агуулгыг Үндсэн хуулийн бусад заалттай уялдуулан авч үзэх нь зүйтэй. Тодруулбал, Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний

⁷ Ж.Бямбаа, “Монгол Улсын Үндсэн хуулийн 2-р бүлгийн арван зургадугаар зүйлийн 12 дахь заалтад өгөх онолын тайлбар” өгүүлэл, Ханнс-Зайделийн сангийн “Эргэцүүлэл” сэтгүүл, 2000, №8, 127 дахь тал.

⁸ Ц.Цогт, “Хүний эрхийг захиргааны эрх зүйгээр хамгаалах Үндсэн хуулийн суурь асуудал” эрдэм шинжилгээний өгүүлэл; Б.Чимид, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2020, 177 дахь тал.

эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”. Мөн зүйлийн 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” хэмээн заасан. Түүнчлэн Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн байдаг. Энэ талаар дараах бүлгүүдэд тодорхой авч үзнэ.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсгийн нэг дэх өгүүлбэр нь Монгол Улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй болохыг баталгаажуулсан билээ. Энэхүү агуулгыг дараах өгүүлбэрт хариу өгөх байдлаар илэрхийлэх боломжтой.

Хэнээс + хэнд хандаж + юуг + хэрхэн = шийдвэрлүүлэх?

Хэнээс? Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ хэмээн заасан хэдий ч дээр эшлэл болгосон Үндсэн хуулийн Арван дөрөв болон Арван наймдугаар зүйлийн дагуу Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй этгээд ч энэхүү өргөдөл, гомдол гаргах эрхийг эдэлнэ.

**Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйл.
Өргөдөл, гомдол гаргах эрх**

1. Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй.
2. Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн өргөдөл, гомдол гаргах талаар Монгол Улсын иргэний адил эрх эдэлнэ.

Хэнд? Монгол Улсын Үндсэн хуулийн гурав, дөрөв, тав, зургадугаар бүлэгт заасан Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын шүүх эрх мэдлийн байгууллага, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц гээд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг бүх байгууллага, албан тушаалтанд хандан өргөдөл, гомдол гаргах эрхийг баталгаажуулж байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуульд нэрлэн зааснаас үл хамааран төрийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагын төв болон орон нутгийн, дээд, дунд, анхан дунд байгууллага, түүнд ажилладаг төрийн албан тушаалтныг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т заасан төрийн байгууллага, албан тушаалтан хэмээн ойлгоно.

Төрийн албан тушаалтан гэж төр, засгийн бүх төрөл, шатны байгууллагад сонгууль буюу томилолтоор, байнга буюу түр, улс төрийн, тусгай болон төрийн захиргааны албан тушаал эрхэлж байгаа хүмүүсийг хамааруулна. Үүнд, багийн Засаг даргаас Улсын Ерөнхийлөгч, төрийн захиргааны анхан шатанд алба хашиж буй түшмэлээс яамдын төрийн нарийн бичгийн дарга, сумын болон дүүргийн шүүгчээс Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Үндсэн хуулийн цэцийн дарга хүртэл бүх албан тушаалтан хамаарна.⁹

⁹ Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2000, 108 дахь тал.

Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2-т заасан Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй хэмээх заалт байх ба түүний тайлбараас үзэхэд удирдах албан тушаалтан, шийдвэр гаргах эрх бүхий этгээдийг хамааруулан ойлгож байна. Харин Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлд төрийн албан тушаалын ангилал, төрлийг заахдаа төрийн улс төрийн албан тушаал, төрийн захиргааны албан тушаал, төрийн тусгай албан тушаал, төрийн үйлчилгээний албан тушаал хэмээн дөрөв ангилсан ба 10 дугаар зүйлийн 10.2-т зааснаар “төрийн албан тушаал нь удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй байна” хэмээн тодорхойлсон тул энэ дөрвөн ангилал, гурван төрлийн албан тушаалыг бүгдийг нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т заасан албан тушаалтан гэдэгт хамааруулж ойлгох нь зүйтэй юм.

Юуг? Өргөдөл, гомдол гэдэг нь хоёр өөр ойлголт бөгөөд энэхүү нэр томъёоны тодорхойлолтыг Г.Совд нарын хамтран бүтээсэн Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбарт өргөдөл гэдэг нь нийгмийн, төрийн, иргэдийн нийтлэг ашиг сонирхолд хохирол учруулахаар оршин байгаа зөрчил, дутагдлыг арилгуулах буюу нийгмийн хэв журам, хууль зөрчсөн асуудлын талаар гаргаж байгаа мэдээллийг хэлнэ гэжээ. Тодорхой хувь хүн өөрийнхөө хууль ёсны эрх ашиг хохирсныг арилгуулахаар гаргаж байгаа мэдээллийг гомдол гэж нэрлэдэг хэмээн тайлбарлажээ.

Хууль зүйн нэр томъёоны хувьд өргөдөл, гомдлыг 1995 оны ИТБАТГӨГШтХ-д тусган зохицуулж ирсэн. Тус хуулийн 4.1-д “өргөдөл” гэж уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх заалтад зааснаас бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлтийг; Өргөдөл нь санал, мэдэгдлийн шинжтэй байж болно. Харин 4.4-т нь “гомдол” гэж төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг хэлнэ хэмээн тодорхойлсон байна. Үүнээс үзэхэд өргөдлийн агуулга нь гомдол гаргахаас бусад

агуулгаар зөвхөн өөрийн субьектив эрхтэй заавал холбоогүй, нийтийн ашиг сонирхол, бүлгийн асуудлаар ч мөн хүсэлт эсхүл мэдэгдэл эсхүл саналын шинжтэй байх боломжтой. Харин гомдол нь зөрчигдсөн эрхийг сэргээлгэх тухай асуудал байх бөгөөд энэ хуулиар мөн л зөвхөн өөрийн субьектив эрх зөрчигдсөн байх шаардлага тавиагүй өргөн хүрээнд хандах эрх нь нээлттэй байна. Мөн энэ эрхийг хэрэгжүүлэхдээ иргэн ганцаараа эсхүл бусадтай хамтран өргөдөл, гомдол гаргах боломжтой.

Өргөдөл, гомдол гаргах хэлбэрийн хувьд аль болох өргөн хүрээнд зохицуулах нь Үндсэн хуулиар баталгаажуулсан энэхүү эрхийг хангах ач холбогдолтой бөгөөд 1995 оны ИТБАТГӨГШТХ-д бичгээр, амаар, цахим сүлжээгээр гаргах боломжтой байхаар зохицуулжээ. Үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх зорилгод нийцүүлэн өргөдөл, гомдолд тавих шаардлагыг хэлбэрийн хувьд хуульд зааж болно. Тухайлбал, өргөдөл, гомдол гаргагч нь нэр, хаяг, холбоо барих мэдээллийг тодорхой бичнэ гэх мэт.

Иргэд бусдыг зориуд санаатай гүтгэсэн, үймээн самуун дэгдээхээр танхай сэдэлтээр хуурамч мэдээлэл өгснөөс бусад тохиолдолд төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлынхоо төлөө ямар нэг хариуцлага хүлээх ёсгүй юм.¹⁰

Хэрхэн шийдвэрлүүлэх? Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй болохыг заахдаа процедурыг буюу хянан шийдвэрлэх ажиллагааг Үндсэн хуульд заагаагүй бөгөөд ердийн хуулиар зохицуулж байна. Өнөөг хүртэл энэ харилцааг зохицуулж ирсэн суурь хууль нь 1995 оны Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (ИТБАТГӨГШТХ) юм. Үүнээс гадна төрийн эрх мэдлийн салаа мөчир, төрийн үйлчилгээ, тодорхой салбар, төрийн байгууллага, албан тушаалтны чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг тусгасан салбарын тухайлсан хуулиудаар мөн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх асуудлыг зохицуулж иржээ. Эрх зүйн ерөнхий зарчмын хүрээнд суурь хууль нь холбогдох

¹⁰ Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2000, 108 дахь тал.

харилцааг салбарын буюу тухайлсан хуулиар зохицуулаагүй нөхцөлд үйлчилнэ гэж үздэг. Тухайлбал, шүүх засаглалын эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл, гомдолтой холбогдох харилцаанд салбарын хуулиудыг баримталдаг. Үүнд эрүү, иргэний хэрэг болон захиргааны зөрчил Үндсэн хуулийн маргаантай холбоотой бүхий л өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Прокурорын тухай, Шүүхийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай, Арбитрын тухай хуулиудаар зохицуулж иржээ.

Хууль тогтоох эрх мэдлийн хүрээний болон захиргааны эрх зүйн харилцааны салбарт хамаарах хууль тогтоомж өргөн хүрээтэй. Тухайлбал, Захиргааны ерөнхий хууль, Авлигын эсрэг хууль, Өрсөлдөөний тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах тухай болон Татварын ерөнхий хууль гэх мэт. Эдгээр хуульд иргэнээс гаргасан өргөдөл эсхүл гомдлын хэлбэр (бичгээр, амаар, цахимаар, бусад), өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэх, өргөдөл, гомдол гаргагчийн эрх ба үүрэг, өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг хянах, түүний мөрөөр ажиллагаа хийх, эцэст нь өргөдөл, гомдол гаргагчид хариу өгөх хүртэлх бүх үе шатны явц, дараалал, хугацаа, өргөдөл, гомдол шийдвэрлэх ажиллагааны хүрээ, хязгаар болон энэ харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хориглох зүйлийг нарийвчлан зохицуулжээ. Энэ талаар дараагийн бүлэгт дэлгэрэнгүй танилцуулна.

Иргэдийн хувьд төрийн байгууллага, албан тушаалтанд хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээг тэр бүр ялгаж мэдэхгүй байх нь түгээмэл бөгөөд ийм нарийн мэдлэгийг шаардах нь амьдралд нийцэхгүй тул төрийн байгууллага, албан тушаалтны эрхлэх асуудал, харьяалах чиг үүргийн талаар нийтэд хүртээмжтэй мэдээллийг байнга түгээж байх нь иргэдийн эрхийг хангах боломж

бүрдүүлнэ. Үүний тулд ердийн бусад хуульд холбогдох процедурыг нарийвчлан заах нь чухал юм. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 199 дүгээр зарлигаар шүүгчээр эргэж томилогдоогүй 12 шүүгч иргэний шүүх, захиргааны шүүх, Үндсэн хуулийн цэцэд хандсан боловч өнөөдрийг хүртэл аль ч шүүхээс эцсийн байдлаар шийдвэрлээгүй байна. Улмаар Улсын Дээд шүүх ба Үндсэн хуулийн цэцээс гаргасан шийдвэрийн дагуу Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар дээрх шүүгчдийн асуудлыг шийдвэрлэхээр харьяалал тогтоогоод хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа билээ. Ингэснээр эдгээр 12 иргэний тухайд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 болон 14-т зааж баталгаажуулсан эрх нь зөрчигдөхөд хүрсэн байна. Тиймээс хууль тогтоомжид өргөдөл, гомдол гаргах, шийдвэрлэх харилцааг нарийвчлан зохицуулах нь чухал бөгөөд чингэхдээ хийдэл, давхардалгүй, хууль хоорондын зөрчилгүй байдлаар зохицуулах шаардлагатай.

ХОЁР. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ХУУЛИЙН ДАГУУ ШИЙДВЭРЛЭХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ҮҮРЭГ

А. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-ын хоёр дахь өгүүлбэрт “...Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” болохыг заасан. Энэхүү агуулгыг дараах өгүүлбэрт хариу өгөх байдлаар илэрхийлэх боломжтой.

Хэн + юуг + юунд үндэслэж + хэрхэн = шийдвэрлэх + хариу өгөх

Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрх нь нэг талаас төрийн байгууллага, түүний үйл ажиллагаанд хяналт тавьж, алдаа дутагдал, зөрчил гажуудлыг арилгах, нөгөө талаас зөрчигдсөн эрхээ төрөөр хамгаалуулах, эцэст нь хууль ёс, нийгмийн дэг журмыг чандлан сахиулах олон талын ач холбогдолтой иргэн, төр хоёрын харилцан тэгш эрх эдэлж, үүрэг хүлээх зарчмын үндсэн нэг хэрэгсэл юм.¹¹ Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн гуравдугаар бүлэгт төрийн эрх мэдлийг хуваарилсан байх бөгөөд тус хууль болон бусад хуулиар төрд олгосон эрх хэмжээний хүрээнд аливаа асуудлыг шийдэх бүрэн эрх, нөгөө талаас иргэн өргөдөл эсвэл гомдол гаргаж эрхээ хамгаалуулах, бусдын эрхийг хамгаалахыг шаардах эрхээс үүдэх харилцааны тэнцвэрийн тухай асуудал юм.

Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүргээ гүйцэлдүүлэхдээ Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, ялангуяа хууль дээдлэх ёсны зарчмыг баримтлах ёстой. Төрийн

¹¹ Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2000, 108 дахь тал.

үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т заасан хууль дээдлэх ёсны зарчмын хүрээнд хэрэгжүүлэх нь эрх зүйт төрийн зарчим юм.

Эрх зүйт төрийн зарчмыг материаллаг болон формаль зарчим гэж ангилдаг. Эрх зүйт төрийн формаль зарчмын гол элементэд захиргааны байгууллага, албан тушаалтан хуульд захирагдах, шүүгч хараат бус байх, шүүх бие даасан байх, төрийн эрх мэдэл хуваарилах зарчмууд хамаардаг. Хууль дээдлэх ёсны зарчим нь төрийн байгууллага, албан тушаалтнаас хууль зөрчсөн аливаа үйлдэл хийхийг хориглох; төрийн байгууллага, албан тушаалтнаас хуульгүйгээр дур мэдэн аливаа үйлдэл хийхийг хориглох; төрийн байгууллага, албан тушаалтнаас хууль ёсны зорилгын үүднээс иргэний эрхэд шаардлагатайгаас илүү хэмжээгээр халдах, хөндөхийг хориглох агуулгыг илэрхийлнэ. Тиймээс иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авсан төрийн байгууллага, албан тушаалтан хуулиар тодорхойлсон чиг, үүрэг, эрх хэмжээний асуудлыг өөр байгууллага руу шилжүүлэх эсхүл ямар нэг байдлаар шийдвэрлэхгүй байх, хариу өгөхөөс татгалзах эрхгүй бөгөөд хэрэв ийм үйлдэл гаргаж иргэний эрхийг зөрчсөн бол хуулийн дагуу тухайн буруутай албан тушаалтан холбогдох хариуцлага хүлээх учиртай. Учир нь хуулиар тодорхойлсон чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн байгууллага, албан тушаалтны хувьд “дур зоргоор” буюу субъектив сонголтоор шийдвэр гаргах тухай ойлголт нь хууль дээдлэх ёсны зарчим, Захиргааны ерөнхий хуульд заасан хуульд үндэслэх зарчмын хувьд хориотой ойлголт юм.

1995 оны ИТБАТГӨГШТХ-д өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх талаар нарийвчлан зохицуулсан байдаг. Тухайлбал, уг хуулийн 7 дугаар зүйлд өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх нийтлэг үүрэг; 12 дугаар зүйлд өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх; 13 дугаар зүйлд өргөдөл, гомдлыг хянан үзэх; 14 дүгээр зүйлд өргөдөл, гомдлыг хянан үзэхгүй байх, буцаах; 15 дугаар зүйлд өргөдөл гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх; 16 дугаар зүйлд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацаа; 17 дугаар зүйлд шийдвэрт гомдол гаргах; 18 дугаар зүйлд өргөдөл, гомдлын талаарх шийдвэрийг биелүүлэх журмыг

тус тус тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл, энэ хуулиар өргөдөл, гомдлыг хүлээн авч, бүртгэхээс эхлээд шийдвэрлэж, хариу өгөх, шийдвэрийг биелүүлэх хүртэлх процессыг журамлан зохицуулж, иргэн хүн эрхээ баталгаатай эдлэх нөхцөл бүрдүүлж өгчээ.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйл.

1. Төрийн бүх байгууллага өргөдөл, гомдол гаргагчийг хүлээн авч уулзах байр, өргөдөл, гомдол хүлээн авах цагийн хуваарийг тогтоож, нийтэд мэдэгдэнэ. Хол газраас ирсэн иргэнийг хүлээлгэлгүйгээр хүлээн авч уулзана.
5. Гомдлыг түүнд холбогдож байгаа албан тушаалтанд өөрт нь шилжүүлэхийг хориглоно.
6. Өргөдөл, гомдлыг албан тушаалтан шууд хүлээн авч болно.
7. “Нууц”, “гарт нь” гэж хаягласан өргөдөл, гомдлыг тухайн албан тушаалтанд шууд өгнө.

Хэрэв иргэд амаар, хөгжлийн бэрхшээлтэй иргэн дохионы хэлээр, гадаадын иргэн, харьяалалгүй этгээд гадаад хэлээр өргөдөл, гомдол гаргаж байгаа бол хүлээн авагч албан тушаалтан буюу түүний төлөөний хүн тэдгээрийг тодорхой тайлбартай нь нарийвчлан тэмдэглэж авах буюу техник хэрэгсэлд бэхжүүлж авах, дохионы хэлээр ярьж буй хүнтэй хэлмэрч, орчуулагчийн тусламжтайгаар харилцан ярилцаж өргөдөл, гомдлыг нь хүлээн авах үүрэгтэй.

Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авсан төрийн байгууллага, албан тушаалтан хуулийн дагуу, хуульд үндэслэн бодит нөхцөл байдал, нотлох баримт цуглуулан, бодитой шийдвэрлэж, заавал хариу өгөх үүрэгтэй. Хуулийн дагуу шийдвэрлэнэ гэдэгт өргөдөл, гомдлын шаардлагыг бүх нөхцөлд заавал хангана гэсэн үг биш харин нөхцөл байдлыг бодитой

тогтоож үндэслэх, харгалзах хүчин зүйлсийг үнэлэн тогтоож өргөдөл, гомдлын агуулга дахь шаардлагыг хангахгүй шийдвэрлэх ч боломжтой. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авсан төрийн байгууллага, албан тушаалтан, шийдвэрлэсэн хариуг заавал тухайн иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэх, хүргүүлэх, өгөх үүрэг хүлээнэ.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйл. Өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх нийтлэг үүрэг.

- 2/ харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдлыг заавал хүлээн авах;
- 3/ өргөдөл, гомдолд дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, үндэслэлтэй шийдвэрлэх;
- 4/ өргөдөл, гомдлыг хугацаанд нь барагдуулах;
- 5/ өргөдөл, гомдолд дурдсан төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;
- 6/ өргөдөл, гомдолд үндэслэл бүхий хариу өгөх;
- 7/ өргөдөл, гомдлын талаар гаргасан шийдвэрийн дагуу харьяа байгууллага, доод шатны албан тушаалтны авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг шалгах.

ИТБАТГӨГШТХ-аас гадна иргэд хамтран бүлгээр буюу оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяаллаар өргөдөл гаргах эрхийн хэлбэрийг Нийтийн сонголын тухай, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулиуд, 2022 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлд онцлог байдлаар зохицуулсан байдаг ба түүнийг хүлээн авч, шийдвэрлэх асуудлыг мөн дээрх хуулиудад тусган зохицуулжээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйл. Нутгийн өөрийн удирдлага дахь иргэний оролцоо.

- 31.1. Сум, баг, дүүрэг, хорооны тулгамдсан асуудлыг хэлэлцэх, зөвлөмж гаргах зорилгоор сонгуулийн эрх бүхий иргэд сайн дураараа хамтарч үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх эрхтэй.
- 31.2. Энэ хуулийн 31.1-д заасны дагуу гаргасан санал, зөвлөмжийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэх үүрэгтэй.
- 31.3. Иргэн сум, дүүргийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар нэг удаагийн эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах эрхтэй. Энэ санаачилгыг сумын сонгуулийн эрх бүхий иргэдийн 10-аас доошгүй, дүүргийн сонгуулийн эрх бүхий иргэдийн таваас доошгүй хувь нь дэмжиж, гарын үсэг зурсан тохиолдолд сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэх үүрэгтэй.
- 31.4. Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шаардлагатай гэж үзвэл нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар гаргах шийдвэрийн талаар хуульд заасны дагуу зөвлөлдөх санал асуулга явуулж болно.

Дээр дурдсан хуулиудын хүрээнд иргэд хүсэлт гаргахад хүлээн авч шийдвэрлэх, хариу өгөх хугацаа гэх мэт процессыг тодорхой заагаагүй байх тул суурь хуульд заасан процессыг дагана гэж ойлгоно. Үүнд захиргааны суурь харилцааг бүхэлд нь нэгтгэн зохицуулж буй гол хууль болох ЗЕХ болон уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй харилцаа, субъектүүдийн хувьд ИТБАТГӨГШТХ-д заасан процессыг баримтлахаар байна. Тухайлбал, иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар

өргөдөл, гомдол гарган шийдвэр гаргагчдын түвшинд хүртэл асуудлын үндэслэлийг хэлэлцүүлэхэд ашигладаг бас нэг механизм нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар байгуулагдан 2012-2020 онд ажиллаж байсан Өргөдлийн байнгын хороо юм. Харамсалтай нь, Өргөлийн байнгын хороо 2020 оны Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд татан буугджээ. Ийнхүү УИХ-д хандсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд тухайлсан хуульд тодорхой заалт байхгүй тул ИТБАТГӨГШТХ үйлчилж байна.

Б. Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь иргэний өргөдөл, гомдол гаргах эрхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг түүвэрлэн авч дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Иргэний өргөдөл, гомдол гаргах эрхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт

№	Хуулийн нэр	Өргөдөл, гомдол гаргах эрхийн зохицуулалт	Шийдвэрлэлтийн процесс
1.	Төрийн албаны тухай хууль ¹²	<p>30 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчийг томилдох үйл ажиллагаанд тавих хяналт</p> <p>30.1. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага өөрөө, эсхүл иргэний гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийнэ.</p> <p>48 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах</p> <p>48.8. Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад, эсхүл шүүхэд гаргаж болно.</p> <p>48.9. Сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журмыг төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран батална.</p> <p>66 дугаар зүйл. Зөвлөлийн бүрэн эрх</p> <p>66.1. Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.</p> <p>66.1.3. иргэн, байгууллага, албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай шаардлага хүргүүлэх, хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох.</p>	<p>75 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсэн тухай маргааныг хянан шийдвэрлэх</p> <p>75.2. Төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигч гомдлоо холбогдох баримт бичгийн хамт төрийн албаны салбар зөвлөл болон төрийн албаны төв байгууллагад 30 хоногийн дотор гаргана.</p> <p>75.3. Төрийн албаны төв байгууллага гомдлыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор маргаан үүсгэх эсэх талаар шийдвэр гаргаж, 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд энэ хугацааг 14 хоногоор сунгаж болно.</p> <p>76 дугаар зүйл. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох</p> <p>76.3. Төрийн албаны төв байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрсөн тал уг шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.</p>

¹² “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2018, №1.

2. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль¹³
- 32 дугаар зүйл. Хяналтын зөвлөлийн шийдвэр**
32.4. Хяналтын зөвлөл бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэрийг гомдол гаргагч эс зөвшөөрвөл шүүхэд хандаж болно.
3. Төрийн аудитын тухай хууль¹⁴
- 19 дүгээр зүйл. Аудитад хамрагдагчийн тайлбар, саналыг сонсох**
19.1. Төрийн аудитын байгууллага аудитын тайлангийн дүнгийн улмаас аудитад хамрагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй тохиолдолд энэ талаар санал, хүсэлт, тайлбар, гомдол гаргах боломжийг олгоно.

33 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх
33.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч нь Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

¹³ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2005, №46.

¹⁴ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2020, №20.

<p>4. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль¹⁵</p>	<p>18.1. Комиссын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.1.1. хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаарх гомдол, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар, эсхүл иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн хүсэлтээр шалгалт хийх; 20 дугаар зүйл. Комисст гомдол, мэдээлэл гаргах эрх 20.1. Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө зөрчсөн талаар Монгол Улсын иргэн дангаар, эсхүл хамтарч энэ хуульд заасны дагуу гомдол, мэдээлэл гаргах эрхтэй. 20.2. Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний нэгэн адил гомдол, мэдээлэл гаргах эрх эдэлнэ. 20.3. Хүүхэд болон иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй, зарим, эсхүл бүрэн бус чадамжтай хүн өөрт хамаарах аливаа асуудлаар бие даан, эсхүл тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээрээ дамжуулан гомдол, мэдээлэл гаргаж болно. 20.4. Сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүний хууль ёсны төлөөлөгч гомдол, мэдээлэл гаргаж болно. 20.5. Ашгийн төлөө бус хуулийн этгээд энэ хуулийн 20.1-д заасан эрхийг эдлэх бөгөөд төлөөлөгчөөрөө дамжуулан гомдол, мэдээлэл гаргана.</p>	<p>23.2. Комисс гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх ба нэмэлт судалгаа, шалгалт хийх шаардлагатай бол Комиссын дарга 30 хүртэл хоногоор сунгаж болно. 23.3. Комиссын бүрэн эрхэд хамаарахгүй гомдол, мэдээллийг ажлын гурван өдөрт багтаан холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ.</p>
<p>25.1. Комиссын гишүүн гомдол, мэдээлэл шалгах чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 25.1.1. гомдол, мэдээлэл гаргасан болон холбогдох иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, түүний удирдлагаас гомдол, мэдээллийн талаар бичгээр болон амаар тайлбар авах; 25.1.2. гомдол, мэдээлэл гаргагч, холбогдох иргэнийг дуудан ирүүлэх; 25.1.3. гомдол, мэдээлэлтэй холбоотой асуудлаар аль ч байгууллага, объект, хуулийн этгээдэд саадгүй нэвтрэн орж, холбогдох албан тушаалтантай биечлэн уулзах.</p>		

¹⁵ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2020, №08.

21 дүгээр зүйл. Гомдол, мэдээлэл гаргах хэлбэр

21.1. Гомдол, мэдээллийг төрийн албан ёсны хэлээр бичгээр, эсхүл амаар гаргана. Монгол хэл мэдэхгүй хүн эх хэлээрээ гомдол, мэдээлэл гаргаж болох бөгөөд монгол хэлээр орчуулж, зохих журмаар баталгаажуулсан байна.

21.2. Амаар биечлэн гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авахдаа тэмдэглэл үйлдэж, гомдол, мэдээлэл гаргагчаар гарын үсэг зуруулна. Хэрэв гомдол, мэдээлэл гаргагч нь бичиг, үсэг мэдэхгүй болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол энэ тухай тэмдэглэл үйлдэж, гомдол, мэдээллийг хүлээн авна.

21.3. Гомдол, мэдээллийг Комиссын цахим шуудан, эсхүл тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан гаргаж болно.¹⁶

26 дугаар зүйл. Комиссын гишүүний гомдол, мэдээлэл шийдвэрлэхтэй холбогдсон бүрэн эрх

26.1. Комиссын гишүүн гомдол, мэдээлэл шийдвэрлэх чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.5. гомдол, мэдээлэл нь эрүү, зөрчлийн шинжтэй гэж үзвэл харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжжүүлэх;

26.1.6. зөрчлийг арилгах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд зөрчил арилгуулахаар гомдол, мэдээллийг шилжжүүлэх, биелэлтийг шаардах;

22 дугаар зүйл. Гомдол, мэдээлэлд тавих шаардлага

22.1. Гомдол, мэдээлэлд дараах зүйлийг тусгасан байна:

22.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний ямар эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн болохыг заах;

22.1.2. гомдол, мэдээлэл гаргагч эцэг /эх/-ийн нэр болон өөрийн нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаараа бичиж, гарын үсгээ зурсан байх;

22.1.3. зөрчигдсэн эрх, эрх чөлөө, болсон нөхцөл байдлын талаар тодорхой дурдаж, нотлох баримтыг хавсаргасан байх;

22.1.4. гомдол, мэдээлэлд холбогдож байгаа байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, түүний удирдлага, хувь хүний нэр, хаяг, утасны дугаар, холбогдох бусад баримтыг хавсаргах;

22.2. Комисс мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг, маргааны талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахгүй - "Төрийн мэдээлэл" эмхэтгэл, 2020, №08.

¹⁶

<p>23 дугаар зүйл. Гомдол, мэдээлэл гаргах болон хянан шийдвэрлэх хугацаа</p>	<p>26.3. Комиссын гишүүн гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаар хуульд заасан журмын дагуу гомдол, мэдээлэл гаргагчид хариу мэдэгдэнэ.</p>
<p>23.1. Гомдол, мэдээлэл гаргагч Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн даруй гомдол, мэдээллээ гаргана. Комисс гомдол, мэдээлэл гаргагчийн эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн, эсхүл зөрчигдсөнийг мэдсэн өдрөөс хойш хоёр жил хүртэлх хугацаанд гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авна.</p>	<p>25³ дугаар зүйл. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавих хяналтыг хэрэгжүүлэх</p> <p>2. Монголбанк нь зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаатай холбогдон гарсан аливаа гомдлыг хянан шалгах, мэдээллийг засаж, үнэн зөв болгох үүргийг холбогдох этгээдэд өгнө.</p>
<p>5. Төв банк /Монголбанк/-ны тухай хууль¹⁷</p>	

¹⁷ "Төрийн мэдээлэл" эмхэтгэл, 1996, №11.

6. Авлигын эсрэг хууль¹⁸
- 6.1. Төрийн байгууллага энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараах нийтлэг үүрэг хүлээнэ:
- 6.1.11. иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;
- 9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх**
- 9.1. Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно.
- 9.2. Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 13 дугаар зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэл**
- 13.2. Улсын Их Хурлын гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо, энэ хуулийн 11.1.2-г заасан хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тус тус өргөдөл, гомдолд үндэслэн шалгах бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зөрчил илэрвэл зохих байгууллагад шилжүүлнэ.
- 13.5. Авлигатай тэмцэх газар өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөг хяналтаар шалгалт явуулж болно.
- 18.4. Авлигатай тэмцэх газар дараах бүрэн эрхтэй:**
- 18.4.6. авлигын холбогдолтой өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах

¹⁸ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2006, №35.

7. Эрүүл мэндийн тухай хууль ¹⁹	43.1.5. хүний эрүүл мэндэд харш үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний талаар холбогдох байгууллагад өргөдөл, гомдол гаргах;
8. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль ²⁰	<p>7.2.3. ард нийтийн санал асуулгын талаар гаргасан өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх;</p> <p>7.3.4. сонгуулийн аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрийг давж заалдсан гомдол болон сонгуулийн асуудлаар гаргасан бусад өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх, хэрэв хууль тогтоомжид нийцээгүй бол тухайн тойргийн хорооны шийдвэрийг хүчингүй болгох;</p> <p>7.4.3. аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрийг давж заалдсан гомдол болон сонгуулийн асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх, хэрэв хууль тогтоомжид нийцээгүй бол тухайн нутаг дэвсгэрийн хорооны шийдвэрийг хүчингүй болгох;</p> <p>14.3. Хэвлэл мэдээллийн зөвлөл нь нам, эвсэл, нэр дэвшигчийн хэвлэл мэдээллийн сурталчилгааны тэнцвэрт байдалд хяналт тавих бөгөөд энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, хуулийн этгээд, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, санал дүгнэлт гаргаж Хороонд танилцуулна.</p>

¹⁹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2011, №21.

²⁰ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2006, №5.

9. Үндсэн хуулийн 9 дүгээр зүйл. Иргэдийн өргөдөл, мэдээллийг хянан шийдвэрлэх шийдвэрлэх
2. Иргэд өргөдөл, мэдээллээ бичгээр үйлдэж, түүнд өөрийн нэр, хаяг, Үндсэн хуулийн ямар заалтыг хэн, хэдийд, ямар байдлаар зөрчсөн тухай тодорхой заасан байвал зохино. Цэц нэр, хаяггүй өргөдөл, мэдээллийг хүлээж авахгүй.
3. Цэцийн гишүүн иргэдийн өргөдөл, мэдээллийг арван дөрвөн хоногийн дотор хянаж, түүнд заасан асуудал нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргаан биш буюу Цэцэд харьяалагдахгүй байвал өргөдөл, мэдээлэл гаргагчид тодорхой үндэслэл бүхий хариу өгнө.
4. Цэцийн гишүүн шаардлагатай гэж үзвэл өргөдөл, мэдээллийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад шилжүүлж өргөдөл, мэдээлэл гаргагчид энэ тухай мэдэгдэнэ.

²¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 1992, №3.

<p>10. Монгол Улсын Их Хурлын тухай хууль²²</p>	<p>8 дугаар зүйл. Гишүүний бүрэн эрх</p> <p>8.1.15. иргэн, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан хариу өгөх, эсхүл харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилж энэ тухай хариу мэдэгдэх;</p> <p>22 дугаар зүйл. Байнгын хороо</p> <p>23.2. Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>23.2.16. өргөдөл гаргагч, холбогдох албан тушаалтан, мэргэжилтнээс тайлбар авах.</p> <p>24.4. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо:</p> <p>24.4.9. гишүүний ёс зүйн асуудлаар ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх.²³</p>
<p>44.4. Тамгын газар дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:</p> <p>44.4.10. гишүүдэд иргэн, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг нэгтгэн дүгнэж Улсын Их Хурлын дарга, холбогдох Байнгын хороо, гишүүдэд мэдээлэх.</p>	

²² “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2020, №22.

²³ Улсын Их Хурлын тухайд иргэн, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаарх Улсын Их Хурал, түүний Байнгын, дэд, түр хороо, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судалж, шийдвэрлэх асуудлыг нарийвчлан зохицуулсан зохицуулалт байхгүй байгаа бөгөөд энэ асуудлыг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу зохицуулж байгаа гэж үзэж байна - Судалгааны баг.

11. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль ²⁴ (2022 оны 5-р сарын 1-нд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлснээр хүчингүй болсон)	17 дугаар зүйл. Гомдол гаргах, гомдлыг хянан шийдвэрлэх 17.1. Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар дээд шатны байгууллага, албан тушаалтан, Хүний эрхийн Үндэсний Комисс, эсхүл шүүхэд гомдол гаргаж болно.	17.2. Энэ хуулийн 17.1-д заасан гомдлыг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг дараах хуулиар зохицуулна: 17.2.1. гомдлыг дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргаж байгаа бол Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль; 17.2.2. гомдлыг Хүний эрхийн Үндэсний Комисст гаргаж байгаа бол Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль; 17.2.3. гомдлыг шүүхэд гаргаж байгаа бол Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.
---	--	---

²⁴ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2011, №26.

<p>12. Татварын ерөнхий хууль²⁵</p>	<p>47 дугаар зүйл. Маргаан таслах зөвлөлд гомдол гаргах, шийдвэрлэх</p> <p>47.1. Татвар төлөгч, эсхүл түүний эрх олгосон итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөх татварын актыг гардаж авснаас хойш энэ хуулийн 43.1, 72.4-т заасан хугацаанд харьяалах Маргаан таслах зөвлөлд гомдол гаргах эрхтэй.</p> <p>47.2. Гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.</p>	<p>47.5. Энэ хуулийн 47.1-д заасан гомдлыг дараах харьяаллын дагуу шийдвэрлэнэ:</p> <p>47.5.1. аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын татварын албанд харьяалагдах татвар төлөгчийн гомдлыг тухайн аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөл;</p> <p>47.15. Маргаан таслах зөвлөл нь татвар төлөгчийн гомдол гаргаснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг шийдвэрлэж, уг шийдвэрийг маргааны оролцогч талуудад гардуулна.</p>
--	---	--

²⁵ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2019, №22.

<p>13. Зар сурталчилгааны тухай хууль²⁶</p>	<p>27 дүгээр зүйл. Зар сурталчилгааны хяналтын байцаагчийн шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах</p> <p>27.1. Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагчийн шийдвэр, үйл ажиллагааг зөвшөөрөөгүй этгээд зар сурталчилгаанд хяналт тавих эрх бүхий байгууллагын даргад гомдол гаргана.</p>	<p>27.2. Оюуны өмчийн улсын хяналтын албаны дарга гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 21 өдөрт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг эрх бүхий албан тушаалтан 14 хүртэл өдрөөр сунгаж болно.</p> <p>27.3. Гомдол гаргах, хүлээн авах, хянах, шийдвэрлэхэд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг баримтална.</p>
<p>14. Гаалийн тухай хууль²⁷</p>	<p>18 дугаар зүйл. Гомдол гаргах хэлбэр</p> <p>18.1. Гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн талаарх гомдлыг бичгээр гаргана.</p>	<p>18.2. Энэ хуулийн 18.1-д заасан гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.</p> <p>18.3. Энэ хуулийн 17.1.1, 17.1.2-г заасны дагуу гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх үүрэг хүлээсэн гаалийн байгууллага, албан тушаалтан шаардлагатай бичиг баримтыг гомдол гаргагчаас гаргуулан авч болно.</p>

²⁶ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2002, №23.

²⁷ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2008, №23.

15. Монгол Улсын 22.7. Яам нь иргэдээс сайдын эрхлэх хүрээний Яамны эрх зүйн асуудлаар гаргасан санал, өргөдөл, гомдлыг Иргэдээс байдлын тухай төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан хууль²⁸ өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хүлээн авч хянан шийдвэрлэнэ.
16. Нийтийн 8.4. Ерөнхий хяналтын сонголыг явуулах тухай иргэн, сонголын хуулийн этгээдээс гаргасан хүсэлт нь доор дурдсан тухай хууль²⁹ шаардлагыг хангасан байна:
- 8.4.1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлага;
- 22.1. Сонголд ажиглагчаар оролцох иргэн, хуулийн этгээд сонгол болохоос ажлын таваас доошгүй хоногийн өмнө Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хүсэлтийг сонгол зохион байгуулагчид хүргүүлнэ.

²⁸ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2004, №16.

²⁹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2015, №29.

17. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль³⁰
- 11 дүгээр зүйл. Олон нийтийн радио, телевизэд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх**
- 11.1. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн техникийн болон мэргэжлийн чанартай холбогдуулан иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг Олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захирал ажлын 15 хоногийн дотор хянан шийдвэрлэж, бичгээр хариу өгнө.
- 11.3. Олон нийтийн радио, телевизэд иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын тухай хуулийг удирдлага болгон Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл батална.
18. Шилэн дансны тухай хууль³¹
- 9 дүгээр зүйл. Иргэний хяналт**
- 9.1. Энэ хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдал болон шаардлагыг байгууллага, албан тушаалтан хүлээн аваагүй бол энэ талаарх гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу төрийн аудитын байгууллагад гаргах бөгөөд энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын үйл ажиллагаанд аудитын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргаж болно.
- 11.2. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн агуулгатай холбогдуулан иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг Олон нийтийн радио, телевизийн Өргөдөл шалгах хороо хянан шийдвэрлэж, бичгээр хариу өгнө.
- 9.2. Төрийн аудитын байгууллага нь гомдол, мэдээллийн дагуу тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тухайн иргэнд бичгээр болон олон нийтэд мэдээлнэ.
- 9.3. Иргэн, хуулийн этгээдийн татвар төлөгчийн эрх ашиг зөрчигдсөн гэж үзвэл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

³⁰ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2005, №8.

³¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2014, №26.

<p>19. Захиргааны ерөнхий хууль³²</p>	<p>92 дугаар зүйл. Захиргааны актад гомдол гаргах 92.1. Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй.</p> <p>92.2. Энэ хуулийн 92.1-д заасан гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өртөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.</p>	<p>94 дүгээр зүйл. Гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх хугацаа 94.3. Гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өртөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүлээн авч, хуульд өөрөөр заагаагүй бол 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө.</p>
--	--	--

³² “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2015, №28.

Дээрх хүснэгтэд үзүүлсэн мэдээллийг харахад иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх харилцааг нэлээд хэдэн тухайлсан хуульд тусгайлан зааж зохицуулжээ. Эдгээрийн заримд хянан шийдвэрлэх хугацаа гэх мэт процессын асуудлыг тусгаагүй байх бөгөөд энэ нөхцөлд дээр өгүүлсэнчлэн суурь харилцааг зохицуулж буй хуулийг мөрдөх юм.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай болон Татварын ерөнхий хууль, Зар сурталчилгааны тухай, Гаалийн тухай, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай, Нийтийн сонсголын тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу иргэний өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэхээр эш татаж зохицуулсан байх аж. Эдгээр хуулиар зохицуулж буй зарим харилцаа нь ЗЕХ-ийн үйлчлэх хүрээнд хамаарах ба тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар холбогдох субъектүүд өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэхэд дагах процесс тодорхой болох, улмаар хуулийн давхардлыг шийдвэрлэх боломж харагдаж байна³³. Тухайлбал, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд³⁴ “шүүхэд гомдол”-оо гаргаж шийдвэрлүүлэхээр заасан бөгөөд ямар хуульд зааснаар гомдлыг хянан шийдвэрлэх тухай харилцааг тодорхой заагаагүй байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 1.1-д “хуулийн

³³ Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Захиргааны байгууллагын үйл ажиллагааг тухайлсан хуулиар зохицуулаагүйгээс бусад харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж заасныг хүчингүй болгосон. Хүчингүй болгосон энэхүү зохицуулалтыг одоогийн УИХ-аар хэлэлцэгдэж байгаа Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд дахин тусгах зохицуулалт оруулсан байна. Ингэснээр ИТБАТГӨГШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг уг хуульд заасан журмаар шийдвэрлэнэ” гэсэн зохицуулалт нь Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэлд хамаарч хэрэгжихээр байна.

³⁴ Тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6-д “мэдээлэл авах эрхийг нь зөрчсөн гэж үзвэл мэдээлэл хариуцагчийн дээд шатны байгууллага, албан тушаалтанд, дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол шүүхэд гомдол гаргах” гэж, 14.2-т “Хүсэлт гаргагч мэдээлэл авах эрхээ хөндөгдсөн гэж үзвэл Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргаж болно” гэж заасан.

зорилго нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход оршино” гэж заасан нь Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасан үйл ажиллагаатай холбогдсон харилцаанд хамаарахаар байна.

Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.5-д “захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлыг хандан гаргах этгээд болон хугацааг заах” гэж тусгасан. Энэ нь сөрөг нөлөөлөл бүхий захиргааны актад³⁵ гомдол гаргахдаа Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлд³⁶ заасны дагуу хэнд хандаж гаргахыг, мөн хугацааг заадаг байна.³⁷

Үүнд:

- Гомдол гаргах захиргааны байгууллагын нэр, хаягийг бичих;
- Захиргааны актыг мэдэгдсэнээс хойш хэд хоногийн дотор гомдол гаргах боломжтой талаар дурдах;

³⁵ Сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт гэж эрх зүйн үйлчлэл чиглэсэн этгээдэд үүрэг бий болгосон эсхүл түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарласан захиргааны актыг ойлгоно - Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсэг.

³⁶ Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй - Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1-д.

³⁷ Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (судалгаа, хэрэглээний), Анхны хэвлэл, УБ., 2017, 194 дэх тал.

- Түүнээс гадна ямар этгээд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэйг дурдана. Тэр нь ихэвчлэн сөрөг нөлөөлөл бүхий захиргааны актын үйлчлэл чиглэсэн этгээд байдаг. Гэвч захиргааны актад дурдагдаагүй этгээд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй.³⁸

Дээрх Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.5 дахь заалт нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд иргэд хаана гомдол гаргахаа мэдэхгүй байгаагаас маш олон газарт хандан цаг алддаг байдлыг арилгахад чиглэсэн дэвшилттэй зохицуулалт юм.

Харин ЗЕХ-ийн үйлчлэл хүрээнд хамаарахгүй харилцааны хувьд хэрхэн зохицуулах вэ?

1. Монгол Улсын Их Хурлын тухайд 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, байгууллагын санал, гомдол, мэдээлэл, эсхүл хяналт шалгалтын үр дүнг үндэслэн гаргасан Улсын Их Хурлын гишүүний саналыг харгалзан Байнгын хорооны хяналт шалгалтын цаглабарт тусгаж хэрэгжүүлж болно” гэж ерөнхий байдлаар тусгажээ. Үүнд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, гомдол, мэдээллийг хяналт шалгалтын цаглабарт тусгаагүй тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар нарийвчлан зохицуулаагүй байна.

Дээрхээс өөр иргэн, хуулийн этгээдээс Улсын Их Хурал, түүний Байнгын, дэд, түр хороо, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судалж, шийдвэрлэх асуудлыг нарийвчилсан зохицуулалт УИХ-ын тухай хуульд байхгүй бөгөөд үүнтэй холбоотой энэ харилцааг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа

³⁸ Жишээ нь, монгол эмэгтэйтэй гэрлэсэн гадаад иргэн зөрчил гаргасан тул захиргааны байгууллага түүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээс гарахыг үүрэг болгов. Энэ тохиолдолд уг шийдвэрийн эсрэг гомдол, нэхэмжлэл гаргах эрхийг зөвхөн тэр гадаадын иргэнд төдийгүй түүний гэр бүлийн гишүүдэд (эхнэр, насанд хүрээгүй хүүхдүүд) ч олгох ёстой. Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи. Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (судалгаа, хэрэглээний), Анхны хэвлэл, УБ., 2017, 194 дэх тал.

ИТБАТГӨГШТХ-аар зохицуулахаас өөр аргагүй байна.³⁹ УИХ-д өргөн баригдаад буй Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар хэлсэн үгэндээ:

*“Улсын Их Хурлын тухайд [...] өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг Төрийн байгуулалтын байнгын хороо баталдаг зохицуулалт байсан. Тэгэхдээ цүннийг нь Улсын Их Хурлын гишүүн тусад нь санаачлах ёстой учраас энэ асуудлыг бол хууль санаачлагчид буцааж байгаа. Тэгээд [...] Их Хуралтай холбоотой асуудлыг нь болбол тусад нь санаачлаад ингээд шийдүүлэхээр явж байгаа. Тийм учраас ямар нэгэн харилцаа бол орхигдохгүй. Харин нэмж ингэж баяжиж бүр тусгагдаж байгаа гэдгийг хэлмээр байна”*⁴⁰ гэсэн бөгөөд тусад нь зохицуулна гэж тайлбарлажээ.

Энэ тохиолдолд иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх процессыг одоо үйлчилж буй ИТБАТГӨГШТХ болон ЗЕХ-ын хүрээнд тогтоосон стандартаас дордуулалгүй, нарийвчлан зохицуулж шийдвэрлэх нь чухал юм.

2. Хууль тогтоомжийн тухай⁴¹ хуульд зааснаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл ажиллагааны явцад (i) эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах;⁴² (ii) хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах⁴³ ажиллагаа хийгдэхээр байгаа. Энэхүү

³⁹ Гэвч 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын танилцуулгад “Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгтэй зөрчилдөж байх тул хууль санаачлагчид нь буцаах зэрэг асуудлыг тусгасан болно” гэж хэлсэн бөгөөд УИХ-д гаргасан иргэний өргөдөл, гомдлыг хэрхэх асуудал тодорхойгүй үлдэж байна.

⁴⁰ 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс.

⁴¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2015, №08.

⁴² Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт.

⁴³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт.

санал авах ажиллагаа нь Нийтийн сонголын тухай хуулийн 7.4-т⁴⁴ заасны дагуу нийтийн сонголотой адил биш болохыг хоёрдмол утгагүй тодорхойлсон байна. Тэгэхээр нийтийн сонгол нь хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд шууд хамаарахгүй гэж үзэн болох юм.

Нийтийн сонголын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т *“Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн сонгол хийх хүсэлтээ иргэн, хуулийн этгээд тухайн асуудал эрхэлсэн Байнгын болон дэд хороонд хандан гаргана”* гэж заасан бөгөөд хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх, нарийвчилсан зохицуулалт мөн тодорхой бус байна.

⁴⁴ Хууль санаачлагч хууль, тогтоомжийн төслийг боловсруулах үе шатанд олон нийтээр тухайн асуудлыг хэлэлцүүлсэн нь хууль тогтоомжийн төслийн сонголыг явуулахгүй байх үндэслэл болохгүй.

ГУРАВ. ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ИРГЭНИЙ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ПРОЦЕСС, ПРАКТИКТ ҮҮСЭЖ БУЙ ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ИТБАТТӨГШТХ нь дөрвөн бүлэг, 21 зүйл, 76 заалттай бөгөөд 1995-2021 он хүртэлх хугацаанд нийт таван удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Эдгээр нэмэлт өөрчлөлтөөр “өргөдөл, гомдол” гэсэн нэр томъёог тодорхойлох; өргөдөл, гомдлыг цахим сүлжээгээр гаргах; өөрийн эрхлэх асуудлын хүрээ, чиг үүрэгт хамаарах асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай, амаар болон бичгээр заавал шийдвэрлэж хариу өгч байх чиглэлээр төрийн байгууллага, албан тушаалтныг үүрэгжүүлэх; тухайн жилд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх дүн мэдээг жил бүр нийтэд тайлагнах, гомдлыг тухайн захиргааны актыг гаргасан байгууллагад эсхүл гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад гаргах зэрэг иргэдийн өргөдөл, гомдлоо шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулсан зарчмын шинжтэй өөрчлөлт нэлээд оруулсан байна.

Гэсэн хэдий ч 27 жилийн өмнө батлагдсан энэхүү хуулийг хэрэгжүүлэх явцад манай орны улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаа өргөжин тэлж, улмаар улсын хөгжлийг даган нийгмийн харилцааг зохицуулах хууль тогтоомжууд шинээр батлагдах, шинэчлэгдэх үйл явц үргэлжилсээр байна. Энэ хугацаанд дээр дурдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Нийтийн сонсголын тухай болон Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хууль тогтоомжийн тухай зэрэг төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зохицуулалт агуулсан олон хууль батлагджээ.⁴⁵

⁴⁵ В.Удвал, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, УБ., 2018, 4 дэх тал.

2015 онд батлагдсан ЗЕХ-ийн 9 дүгээр бүлэгт “Захиргааны актад гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх журам”-ын зохицуулалтыг нэлээд нарийвчлан тусгасан. ЗЕХ-ийн 92 дугаар зүйлийн 92.2-т захиргааны актад гаргах гомдолд тавигдах шаардлагыг тодорхойлохдоо ИТБАТГӨГШТХ-ийн 10 дугаар зүйлийг эшилсэн байх тул ЗЕХ-ийн дагуу гомдлыг хянан шийдвэрлэхэд уг хуулийг мөн давхар хэрэглэж байна.⁴⁶

Хуулиудыг харьцуулан үзвэл ЗЕХ-ийн болон ИТБАТГӨГШТХ-д нэг харилцааг зарим талаар давхардуулан, зарим талаар ялгаатай зохицуулжээ. Эдгээр нийтлэг болон ялгаатай талыг Хүснэгт 2-т харуулав.

⁴⁶ Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг: Өргөдөл, гомдлын хуулийг Захиргааны ерөнхий хуулийг анхлан батлах явцад нэгтгэх үү, үгүй юу гэдэг хэлэлцүүлэг бас тухайн үедээ яригдаж байсан. Тэгээд энэ асуудлыг ер нь цаашдаа судалж, анхаарч үзье гэдэг чиглэлээр тухайн үедээ Захиргааны ерөнхий хуулийг баталж байсан протоколтой байгаа. Энэ дээр одоо иргэдийн өргөдөл, гомдол гаргах энэ эрхийг дордуулах асуудал байхгүй байгаа. Өнгөрсөн болон одоогийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хийгээд одоо энэ шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр ч тэр иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, өргөдөл, гомдлоо гаргах бололцоог нь цаасан болон бүхий л хэлбэрээр буюу цахим хэлбэрээр олгох асуудлууд тусаж байгаа. Дээрээс нь бас төрийн байгууллага талдаа хариуцлагатай байж ерөнхийдөө хуучин гуч хоногийн дотор өргөдөл, гомдолд хариу өгөх ёстой, гуч хоногоор сунгаад явдаг энэ харилцаануудыг бид багасгаж байгаа. Өөрөөр хэлбэл, нэгэнт төр түргэн шуурхай байх үүднээсээ хорин нэгэн хоногийн дотор өргөдөл, гомдол гаргах энэ харилцааг нь одоо өгөх ёстой шүү гэдэг. Энэ нь бас иргэд талдаа ийм давуу байдалтай зохицуулалтууд орж байгаа. Хоёрдугаарт, ер нь өргөдөл, гомдол гаргасны дараа яг захиргааны үйл ажиллагаа буюу энэ захиргааны акт гарч байгаа. Тэгтэл өргөдөл, гомдлын хуулиараа бас тодорхой өргөдөл, гомдол гаргана. Захиргааны ерөнхий хуулиар бас өргөдөл, гомдол гаргах ч юм шиг. Тэгээд ер нь яг аль процедурын дагуу иргэнд хариу өгөх юм бэ гэдэг энэ асуудлыг энэ хуулиараа тодорхой болгож, цаашдаа иргэдийн энэ өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл авах, төрийн байгууллагууд бас үйлчилгээ авах эрхийг нь илүү баталгаажуулж өгч байгаа гэдэг зүйлийг танд хэлмээр байна. Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс. <http://www.parliament.mn/files/122705>

Хүснэгт 2. Давхардсан зохицуулалтууд

Захиргааны ерөнхий хууль

ИТБАТГӨГШТХ

1. Гомдлыг хянан шийдвэрлэх байгууллага, өргөдөл, гомдол гаргах талаар:

ЗЕХ-ийн 93 дугаар зүйлийн 93.1-д “иргэн, хуулийн этгээд гомдлыг тухайн захиргааны актыг гаргасан байгууллагын дээд шатны захиргааны байгууллагад, эсхүл гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад гаргана”.

ИТБАТГӨГШТХ-ийн 11 дүгээр зүйлийн 2-т “Гомдлыг түүнд холбогдож байгаа байгууллага, албан тушаалтныг харьяалсан дээд шатны байгууллага, албан тушаалтанд, харьяалсан дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол тухайн захиргааны актыг гаргасан байгууллагад, эсхүл гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллагад гаргана”.

2. Гомдол шийдвэрлэх хугацаа:

ЗЕХ-ийн 94 дүгээр зүйлийн 94.3-т “Гомдлыг ИТБАТГӨГШТХ-д заасны дагуу хүлээн авч, хуульд өөрөөр заагаагүй бол 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө. Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.4-т Шаардлагатай тохиолдолд уг хугацааг захиргааны байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор сунгаж болох бөгөөд энэ тухай гомдол гаргасан иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэнэ”.

ИТБАТГӨГШТХ-ийн 16 дугаар зүйлийн 1-д “өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэлх хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ”.

3. Гомдлыг шийдвэрлэсэн захиргааны актыг мэдэгдэх

Захиргааны ерөнхий хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д “Гомдлыг хянан шийдвэрлэсэн захиргааны байгууллага энэ тухай захиргааны акт гарсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор гомдол гаргагч этгээдэд бичгээр мэдэгдэж, түүнийг баримтжуулна”.

ИТБАТГӨГШТХ-ийн 15 дугаар зүйлийн 4-т “өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн, эсхүл энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээ авсан тохиолдолд энэ тухай хариуг биечлэн амаар буюу харилцах утсаар, эсхүл бичгийн зэрэг тохиромжтой хэлбэрээр мэдэгдэнэ”.

Хуулиудыг харьцуулан үзвэл захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх

харилцааг зохицуулж байгаа харилцаанд хуулийн давхардал үүссэн байгаа нь тодорхой харагдах бөгөөд практикт ИТБАТГӨГШТХ-ийг хэрэглэж байна.⁴⁷ Тухайлбал:

Тохиолдол 1

Нэхэмжлэгч О.Э нь Цагдаагийн ерөнхий газрын дарга, Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газарт холбогдуулан Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газрын ажилтнаар томилох шийдвэр гаргаагүй Цагдаагийн ерөнхий газрын дарга, Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, ажилгүй байсан 2013 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2014 оны 3 дугаар сарын 09-ний өдөр хүртэлх хугацааны цалин төгрөгийг гаргуулах” тухай нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: “Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн зүгээс нэхэмжлэгчид бичгээр хариу өгөөгүй, гэрч Н.Л, С.Э нар нь утсаар болон биеэр хариу өгсөн гэх боловч энэ талаар үйлдсэн тэмдэглэл байхгүй тул Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд “1. Өргөдөлд дурдсан асуудлыг шууд шийдвэрлэх боломжтой бол зохих шийдвэрийг гаргана. 2. Шууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал (орон сууц олгуулах гэх мэт)-аар гаргасан өргөдлийг тусгай бүртгэлд бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавина. 3. Гомдлыг албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ. 4. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн, эсхүл энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээ авсан тохиолдолд энэ тухай хариуг биечлэн амаар буюу харилцах утсаар, эсхүл бичгийн зэрэг тохиромжтой хэлбэрээр мэдэгдэнэ. 5. Хариуг амаар, харилцах утсаар мэдэгдсэн бол энэ тухай бүртгэлд тэмдэглэнэ” гэж тус тус заасны дагуу нэхэмжлэгчид хариу өгсөн, өргөдлийг шийдвэрлэсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

⁴⁷ Энэ судалгаанд авч үзсэн хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэрүүдийн жагсаалтыг Хавсралт 2-оос харна уу.

Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч О.Э сүүлийн өргөдлийг хариуцагч Цагдаагийн ерөнхий газарт ирүүлсэн баримт байхгүй, тус газарт хийсэн баримт бичгийн үзлэгээр тогтоогдохгүй байх хэдий ч хариуцагч Цагдаагийн ерөнхий газрын дарга нь Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсээс ирүүлсэн 2014 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн тодорхойлолтыг үндэслэн томилсон үйлдэлтэй нэхэмжлэгч, хариуцагч талууд маргаагүй, Цагдаагийн ерөнхий газрын дарга нь 2014 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн тушаалаар нэхэмжлэгчийг ажилд томилон өргөдлийг хуулийн хугацаанд багтаан шийдвэрлэсэн нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ” гэж заасныг зөрчөөгүй байх тул “өргөдлийг шийдвэрлээгүй эс үйлдэхүй” байсан гэж дүгнэх боломжгүй. Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6-д “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна”.

Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.14-т “Ажил, үүргээ гүйцэтгээгүй үед ажил, албан тушаалыг дараах тохиолдолд хэвээр хадгална: жирэмсний болон амаржсаны амралттай болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа”; Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд “2. Шууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал (орон сууц олгуулах гэх мэт)-аар гаргасан өргөдлийг тусгай бүртгэлд бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавина. 3. Гомдлыг албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ. 4. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн, эсхүл энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээ авсан тохиолдолд энэ тухай хариуг биечлэн амаар буюу харилцах утсаар, эсхүл

бичгийн зэрэг тохиромжтой хэлбэрээр мэдэгдэнэ. 5. Хариуг амаар, харилцах утсаар мэдэгдсэн бол энэ тухай бүртгэлд тэмдэглэнэ”; 16 дугаар зүйлийн 16.1-д “Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ” гэж тус тус заасны дагуу нэхэмжлэгч О.Э Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газарт хандан 2013 оны 09 дүгээр сарын 20, 2014 оны 3 дугаар сарын 17-ны өдөр тус тус гаргасан өргөдлийг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоон 2013 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2014 оны 5 дугаар сарын 09-ний өдрийг хүртэлх хугацааны 7 сар 19 хоног (ажлын 15 хоног)-ийн цалинг Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газраас гаргуулж нэхэмжлэгч О.Э-д олгох нь зүйтэй гэж үзлээ” гэж шийдвэрлэжээ.⁴⁸

Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт: “Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3, 15.4, 15.5, 16.1-д тус тус заасныг баримтлан шаардлагын зарим хэсгийг хангаж О.Э-г Сүхбатаар аймаг дахь Цагдаагийн газрын ажилтнаар томилох шийдвэр гаргахтай холбоотой өргөдлийг шийдвэрлээгүй хариуцагч Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газрын эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, өргөдөл гаргасан 2013 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2014 оны 5 дугаар сарын 09-ний өдөр буюу Цагдаагийн ерөнхий газрын даргад мэдэгдэх хүртэлх хугацааны 5,858,116 (Таван сая найман зуун тавин найман мянга нэг зуун арван зургаа) төгрөгийг тус газраас гаргуулан нэхэмжлэгчид олгож, харин Цагдаагийн ерөнхий

⁴⁸ https://shuukh.mn/single_case/2057?daterange=2016-01-01%20-%202016-12-30&id=1&court_cat=3&bb=1

газарт холбогдох нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай” гэж шийдвэрлэсэн байна..

Тохiolдол 2

Нэхэмжлэгч “Д ю” ХХК нь АМГТГ, (Ашигт малтмал, газрын тосны газар), Кадастрын хэлтсийн дарга нарт холбогдуулан “Д ю” ХХК-ийн Дархан-Уул аймгийн Шарынгол суманд байрлах “Шарын гол” нэртэй хайгуулын талбайд ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулах XV-014955 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдлийг хүлээн авахгүй байгаа эс үйлдэхүйг хууль бусад тооцож, тусгай зөвшөөрлийн хугацааг дуусгавар болгон бүртгэсэн бүртгэлийг хууль бусад тооцож, дээрх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдлийг хүлээн авахыг даалгах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: “Ашигт малтмалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас нэг сарын өмнө түүнийг эзэмшигч нь хугацааг сунгуулах тухай өргөдлийг төрийн захиргааны байгууллагад гаргах”-аар, 22.2-т “...тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 7.2, 31 дүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянаж, зөрчилгүй бол тусгай зөвшөөрлийн хугацааг мөн хуулийн 21.1.5-д заасан хугацаагаар сунгах”-аар, 22.4-т “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 7.2, 31 дүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй бол төрийн захиргааны байгууллага хугацаа сунгахаас татгалзах”-аар тус тус зааснаас үзвэл хариуцагч захиргааны байгууллага нь хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авсны үндсэн дээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах эсхүл сунгахаас татгалзах шийдвэр гаргах агуулгатай байна.

Мөн Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т зааснаар төрийн байгууллага, албан тушаалтан нь харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдлыг

заавал хүлээн авах үүрэгтэй. Хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтууд болон хэргийн оролцогчдын тайлбар, гэрчүүдийн мэдүүлгээс нэгтгэн үзвэл “Д ю” ХХК нь XV-014955 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн дуусах хугацаа буюу 2018 оны 06 дугаар сарын 25-наас 21 өдрөөс өмнө хугацаа сунгуулах хүсэлтээ өгөхөөр захиргааны байгууллагад хандсан болох нь үгүйсгэгдэхгүй байна” гэжээ.

Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт: “Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.14, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “О У М” ХХК-аас Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргад гаргасан өргөдлийг хүлээн авч шийдвэрлэхдээ хууль зүйн үндэслэлгүй татгалзсан нь хууль бус болохыг тогтоож, “О У М” ХХК-ийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэхийг хариуцагч Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст даалгасугай” гэж шийдвэрлэжээ.⁴⁹

2016-2021 онд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргааныг түүвэрлэн үзэхэд захиргааны байгууллага гомдол хүлээн авах, шийдвэрлэх, эс үйлдэхүйгээр шийдвэрлэхгүй байх, мэдэгдэх гэх мэт харилцааг ИТБАТГӨГШТХ-аар зохицуулж шийдвэрлэсэн, мөн шүүх үндэслэл болон тогтоох хэсэгтээ уг хуулийг баримтлан хэрэг маргааныг шийдвэрлэсэн байна.

Өмнө өгүүлсэнчлэн эрх зүйн ерөнхий зарчмын хүрээнд суурь хууль нь тухайн холбогдох харилцааг тухайлсан хуулиар зохицуулаагүй нөхцөлд үйлчилнэ гэж үздэг. Гэтэл энэ тохиолдолд ЗЕХ-ийг бус ИТБАТГӨГШТХ-ийг хэрэглэж буй нь ЗЕХ-д өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой зарим харилцааг нарийвчлан тусгалгүй орхигдуулсантай холбоотой бөгөөд хууль хэрэглээний ойлгомжгүй байдал үүсгэж байна. Цаашид төрийн гүйцэтгэх

⁴⁹ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2019 оны 05 сарын 24 өдөр, Дугаар 316. https://shuukh.mn/single_case/6102?daterange=2010-01-01%20-%202020-01-16&id=1&court_cat=3&bb=1

засаглалын салаа мөчрийн үйл ажиллагааг зохицуулж буй гол хууль болох ЗЕХ-ийн хүрээнд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй боловч ИТБАТГӨГШТХ-ийг заавал хүчингүй болгох шаардлага бий эсэх, хүчингүй болгосон тохиолдолд тухайлсан хуульд нь өргөдөл, гомдолтой холбоотой харилцааг зохицуулсан заалт байхгүйн улмаас үндсэн эрх зөрчигдөх нөхцөл үүсэх эсэх асуудлыг нухацтай авч үзэх нь зүйтэй.

ДӨРӨВ. ЗЕХ-Д ТУСГАХААР БОЛОВСРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ НЬ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГАРГАЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ ЭРХИЙГ ХАНГАН БАТАЛГААЖУУЛАХ БАЙДАЛ

ЗЕХ-д тусгахаар боловсруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд ИТБАТГӨГШТХ-ийг заавал хүчингүй болгох асуудлыг хэлэлцэж буйтай холбоотой юуны өмнө уг нэмэлт, өөрчлөлтийн төсөлд “өргөдөл, гомдол” шийдвэрлэхтэй холбоотой шинээр туссан зохицуулалтыг одоо хүчин төгөлдөр үйлчилж буй ЗЕХ болон ИТБАТГӨГШТХ-ийн холбогдох зохицуулалтуудтай харьцуулан авч үзье.

1. Одоогийн мөрдөгдөж буй ЗЕХ болон ИТБАТГӨГШТХ-д өргөдөлтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүй байсныг ЗЕХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 91 дүгээр бүлэг болгон нэмж дараах агуулгын хүрээнд тодорхой заалтууд тусган зохицуулсан байна.⁵⁰ Үүнд:

- Өргөдөл гаргах эрх;
- Өргөдөл гаргагчийн эрх;
- Өргөдөл гаргах;
- Өргөдөл шийдвэрлэх;
- Өргөдлийн талаарх шийдвэрийг биелүүлэх;
- Шийдвэрт гомдол гаргах.

2. Гомдлын үнэн зөвийг хариуцах талаар ИТБАТГӨГШТХ-ийн 8 дугаар зүйлийн 2-т “өргөдөл, гомдол үнэн зөв байна” гэж заасан байдаг бол Захиргааны ерөнхий хуульд уг асуудалтай холбоотой харилцааг огт зохицуулаагүй байсныг нэмэлт, өөрчлөлтийн төсөлд

⁵⁰ “Өргөдөл нь гомдлоос бусад захиргааны байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар гаргасан саналын шинжтэй эсхүл хуульд заасан өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх талаар гаргасан хүсэлтийн шинжтэй байна” гэж Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээр Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд дэмжигдсэн санал.

“гомдлын үнэн зөвийг гомдол гаргагч хариуцна” гэж илүү тодорхой тусгажээ. Мөн гомдлыг хэрхэн гаргах, гомдолд байх шаардлага зэргийг дэлгэрэнгүй байдлаар оруулсан байна.

3. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацааны хувьд:

- ЗЕХ-ийн 94 дүгээр зүйлийн 94.3-т “Гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүлээн авч, хуульд өөрөөр заагаагүй бол 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө”;
- ИТБАТГӨГШТХ-ийн 16 дугаар зүйлийн 1-д “Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ” гэж тус тус заасныг ЗЕХ-ийн төсөлд тусгахдаа богиносгож буюу 21 хоногийн дотор шийдвэрлэхээр заажээ.

Мөн шаардлагатай тохиолдолд уг хугацааг захиргааны байгууллагын удирдах албан тушаалтан 21 хоногоор сунгахаар зохицуулжээ. Өнөөгийн нийгэм, техник технологийн хөгжил, захиргааны байгууллагын чиг хандлага хурдацтай өөрчлөгдөж байгааг харгалзан иргэн, хуулийн этгээдэд захиргааны байгууллагаас учруулах хүндрэл бэрхшээлийг багасгахад энэ өөрчлөлт нь чухал дэвшил болжээ гэж үзэж байна.

4. ИТБАТГӨГШТХ-ийн 5 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй” гэж заасан байдаг. Энд өргөдөл, гомдол гаргагчийг “иргэн” гэж тухайлан заасны улмаас “хуулийн этгээд”-ээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх асуудал орхигдох үр дагавар үүсдэг. ЗЕХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 99¹.1-д “Монгол Улсын иргэн, хуулийн этгээд дангаараа буюу хамтарч энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан байгууллагад өргөдөл гаргах эрхтэй” байхаар тусгасан байна.

Мөн ЗЕХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 99¹.2-т “Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн өргөдөл гаргах талаар Монгол Улсын иргэний адил эрх эдэлнэ” гэж заасан нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2-т заасан “гадаадын иргэн, харьяалалгүй хүн”-ий өргөдөл гаргах эрхийг хязгаарлаагүй байна.

5. ИТБАТГӨГШТХ-ийн 9 дүгээр зүйлийн 1-д “Өргөдөл, гомдлыг төрийн албан ёсны хэлээр бичгээр буюу амаар гаргана. Өргөдөл, гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно” гэж заасан байдаг. Харин Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “өргөдөл”-ийн талаарх харилцааг зохицуулаагүй байсныг дэлгэрүүлэн тусгасан байна.

Хуралдааны тэмдэглэлээс⁵¹:

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт: Улсын Дээд шүүхийн Захиргааны танхимын шүүгч Гочоогийн Банзрагч ажлын хэсэгт ажиллаж байгаа. Яг Захиргааны хуулиар бас мэргэшсэн ийм шүүгч гэж ойлгож байгаа. Тэгэхээр төрийн байгууллага, ажилтан, албан тушаалтанд иргэдээс өргөдөл, гомдол гаргах хууль нь алга болчхож байгаа. Төрийн байгууллага, албан тушаалтанд иргэд болон хуулийн этгээдийн гомдол гаргах процессыг илүү нарийвчилсан, хөнгөвчилсөн, иргэддээ ээлтэй, илүү давуу эрхтэй энэ асуудал шийдэгдэж байгааг ярьж байна л даа. Энэ дээр та одоо бас яг өмнөх хуультай нь харьцуулаад үнэхээр энэ хууль дэвшилттэй болж чадаж байгаа юу? Үүнийг бас нэмээд тодруулж хариулж өгөөч.

Улсын Дээд шүүхийн шүүгч Г.Банзрагч: Өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль байсан. Энэ хуулиас гадна мөн Захиргааны ерөнхий хууль дээр гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа зохицуулдаг байсан. Тэгэхээр зарим талаараа

⁵¹ Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээс. <http://www.parliament.mn/n/6yzyn>

энэ гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа нь давхцаад аль хуулиараа одоо иргэд, байгууллага хандах вэ гэдэг нь бас ойлгомжгүй нөхцөл байдал үүсгэдэг байсан. Тэгэхээр энэ Захиргааны ерөнхий хууль гэдэг маань өөрөө захиргааны байгууллагуудад хамааралтай. Нийтлэг хууль гэдэг утгаараа өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа нь энэ хуульдаа нэгдсэн байдлаар, бүхэл бүтэн бүлэг болж орж байгаагаараа иргэдэд илүү ойлгомжтой байх юм.

Мөн сая гишүүний хэлсэнчлэн зарим нэг дэвшилттэй заалтууд орсон. Өмнөх хуулиасаа дордсон зүйл байхгүй гэж ойлгож болно. Яах вэ, зүгээр ер нь Өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн гол агуулга маань Захиргааны ерөнхий хуулиас ялгаатай нь юу байсан бэ гэхээр Өргөдөл, гомдлын тухай хуулиар бол өргөдөл, гомдолд тодорхой хэлбэржсэн хэлбэрийн шаардлагыг тавихгүй эсвэл одоо тухайн иргэн ямар ч асуудлаар заавал өөрийн эрх ашгийг хөндсөн гэдэг асуудлаар биш, ямар ч асуудлаар, хэзээ ч, ямар ч байдлаар хандах боломжтой. Одоо хууль зүйн хувьд хэлбэржээгүй эрх зүйн хамгаалалтын зохицуулсан хууль байсан байгаа юм. Гэхдээ яах вэ, энэ маань сая ерөнхий хуульд, энэ ерөнхий хуулийн төсөлд орсноор хязгаарлагдаад байгаа асуудал байхгүй. Мөн л тухайн иргэн өөрт хамааралтай болоод хамааралгүй асуудлаар хандах боломж нь байна аа гэж харж байгаа.

Эндээс үзэхэд ИТБАТГӨГШТХ, ЗЕХ-д дутуу тусгасан зарим асуудлыг ЗЕХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нарийвчлан тусгасан байхын зэрэгцээ төрийн үйл ажиллагааны түргэн шуурхай, ойлгомжтой байдлыг хангахад чиглэсэн дэвшилттэй өөрчлөлтүүд мөн тусгалаа олжээ.

Захиргааны суурь харилцааг бүхэлд нь нэгтгэн зохицуулж буй гол хууль болох ЗЕХ-ийн үйлчлэх хүрээнд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх процессыг ийнхүү нарийвчлан зохицуулж, хууль хоорондын давхардал, хийдлийг арилгах, боловсронгуй болгох нь чухал юм. Ингэснээр иргэн, хуулийн этгээд аль хуулийнх нь дагуу төрийн байгууллагад хандах асуудал ойлгомжгүй, хууль хоорондын

давхардал, зөрчил үүсээд байсан асуудал нэг мөр шийдэгдэх сайн талтай. Тухайлбал, иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдол шийдвэрлэхтэй холбоотой харилцааны гомдолтой холбоо бүхий хэсгийг Захиргааны ерөнхий хуулийн 9 дүгээр бүлэгт, өргөдөлтэй холбоотой хэсгийг нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд боловсруулсан 91 дүгээр бүлгээр нэгтгэн зохицуулснаар ИТБАТГӨГШТХ-ийг давхар ашиглах шаардлагагүй болж иргэн, хуулийн этгээдэд илүү ойлгомжтой болно гэж үзэж байна.

ЗЕХ-д хуулийн зорилгыг тодорхойлохдоо “нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэхэд оршино” гэжээ. Энэ үйлчлэх хүрээнээс гадна өөр хүрээнд ЗЕХ үйлчлэхгүй бөгөөд энэ тохиолдолд ИТБАТГӨГШТХ-ийг ашиглаж буй нэг жишээ нь Улсын Их Хурал, түүний Байнгын, дэд, түр хороо, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судалж, шийдвэрлэх асуудал болохыг өмнө дурдсан билээ.

Суурь хууль нь хүчингүй болчихоор дээрх шиг салбарын тухайлсан хуульд нь өргөдөл, гомдол шийдвэрлэх процессыг тусгаагүй нөхцөл үүсвэл яах вэ гэсэн асуулт тодорхойгүй үлдэж байгааг анхаарах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т заасан төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх нь иргэн, төрийн харилцааны тэнцвэрийг хангах, зөрчигдсөн эрхийг хамгаалах тогтолцоонд чухал ач холбогдолтой үндсэн эрх билээ. Энэхүү эрхээ иргэд баталгаатай эдлэхэд процедурыг нарийвчлан зохицуулсан хууль чухал бөгөөд өнөөг хүртэл энэ харилцааг зохицуулж ирсэн суурь хууль нь 1995 оны Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (ИТБАТГӨГШТХ) юм. Гэвч энэхүү хуулийг баталснаас хойших 27 жилийн хугацаанд улс орны улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаанд гарсан өөрчлөлтүүдтэй холбоотой нийгмийн харилцааг зохицуулах хууль тогтоомжууд шинээр батлагдах, шинэчлэгдэх үйл явц үргэлжилсээр байна. Үүний нэг нь Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Захиргааны ерөнхий хууль (ЗЕХ) юм. Уг хууль нь Монгол Улсад анх удаа захиргааны суурь харилцааг бүхэлд нь нэгтгэн зохицуулснаараа эрх зүйн хөгжилд болон захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, иргэдийн оролцоог хангадаг болгоход чухал түлхэц болсон юм. Гэвч хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим нэг саад бэрхшээл тулгарч буйн нэг нь захиргааны байгууллагад гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх асуудал юм. Уг харилцааг зохицуулах зарим заалт хуульд туссан боловч бүрэн гүйцэд хуульчлаагүйн улмаас практикт ИТБАТГӨГШТХ-ийг ашиглах нь түгээмэл байна. ИТБАТГӨГШТХ-д өргөдөл ба гомдол гэсэн хоёр тусдаа ойлголтыг нэгтгэн зохицуулсан байх ба захиргааны актад гаргасан гомдлыг нь уг хуулийн өргөдлийг (санал, мэдэгдлийн шинжтэй) шийдвэрлэх зохицуулалтаар шийдэх нь нийтлэг тохиолдож байна.

Тиймээс хууль хоорондын давхцал, хийдлийг арилгаж захиргааны байгууллагад иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх процессын зохицуулалтыг Захиргааны ерөнхий хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэж байна. Ингэснээр өргөдөл,

гомдол гаргах ажиллагаа төрөлжсөн хуулиар зохицуулагдах боломж нээгдэх сайн талтай. ЗЕХ-д тусгахаар боловсруулсан нэмэлт, өөрчлөлтийг авч үзэхэд ИТБАТТӨГШТХ-ийн үндсэн эрхийг хангахад чиглэсэн агуулга илүү боловсронгуй болж туссан байна. Тухайлбал, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Захиргааны ерөнхий хууль болон Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд “өргөдөл”-тэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүй байсныг Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр зохицуулж байгаа нь хуулийг нэг мөр ойлгох боломж бүрдүүлжээ⁵².

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй.”, 2-т “Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн өргөдөл, гомдол гаргах талаар Монгол Улсын иргэний адил эрх эдэлнэ” гэж заасан. Өргөдөл, гомдол гаргагчийг “иргэн” гэж тухайлан заасны улмаас “хуулийн этгээд”-ээс гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх асуудлыг орхигдуулсныг хуулийн төсөлд нэмж тусгасан байна.

Түүнчлэн өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацааг илүү богиносгож байгаа нь иргэн, хуулийн этгээдэд захиргааны байгууллагаас учруулах хүндрэл бэрхшээл, хүнд суртлыг багасгахад чиглэсэн байна гэж үзэж байна.

Харин ЗЕХ-ийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд ИТБАТТӨГШТХ-ийг хүчингүй болгох аваас ЗЕХ-ийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй харилцаа болон төрийн байгууллага, албан тушаалтнуудтай холбоотой өргөдөл, гомдол шийдвэрлэх асуудлыг хэрхэн

⁵² “Өргөдөл” нь гомдлоос бусад захиргааны байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар гаргасан саналын шинжтэй эсхүл хуульд заасан өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх талаар гаргасан хүсэлтийн шинжтэй байна” гэж Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээр Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд уг санал дэмжигдсэн байна.

нарийвчлан зохицуулахыг нухацтай авч үзэх шаардлагатай. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурал нь иргэн, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаарх Улсын Их Хурал, түүний Байнгын, дэд, түр хороо, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судалж, шийдвэрлэх асуудлыг нарийвчлан тусгасан зохицуулалт байхгүй. Энэ асуудлыг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа ИТБАТТӨГШтХ-ийн дагуу зохицуулж байгаа бөгөөд энэ хууль хүчингүй болсон тохиолдолд гомдлыг хэрхэн шийдвэрлэх асуудлыг тодорхой болгох шаардлагатай. Ингэхийн тулд Улсын Их Хурлын тухайд өргөдөл, гомдол шийдвэрлэх журмыг Төрийн байгуулалтын байнгын хороо ЗЕХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлахтай зэрэгцүүлж, хамтатган батлах шаардлагатай байна.

ХАВСРАЛТ 1. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Бүгд Найрамдах Энэтхэг Улс

Иргэдээс төрийн байгууллагад хандаж гаргасан өргөдөл гомдол, санал хүсэлтийг төрийн захиргааны байгууллагууд нь дотооддоо баталсан “Иргэний эрхийн тунхаг бичиг” (*Citizens’ charter*) болон дотоод журмаараа зохицуулдаг байна.

Тус улсад төрийн захиргааны аль ч шатны байгууллагад иргэд санал хүсэлт, өргөдөл, гомдол гаргах эрхтэй. Засгийн газрын харьяа ихэнх яам, агентлаг дотооддоо иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хэлтэс, газартай бөгөөд долоо хоног бүрийн Лхагва гаригт иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авдаг. Иргэний өргөдөл, гомдол хариуцсан эдгээр хэлтэс, газрын үйл ажиллагаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Иргэдийн өргөдөл, гомдол хариуцсан зөвлөл ерөнхийд нь хяналт тавьдаг байна. Иргэдээс төрийн байгууллагад хандаж гаргасан нийт өргөдөл, гомдол, санал хүсэлтийн хариу, шийдвэрлэлтэд төрийн захиргааны дээд шатны буюу Засгийн газрын бүтцийн хоёр байгууллага анхаарч ажилладаг. Үүнд:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Иргэдийн өргөдөл, гомдол хариуцсан зөвлөл (*Directorate of Public Grievances, Cabinet Secretariat*);
2. Хүний нөөц, тэтгэвэр тэтгэмж, өргөдөл, гомдлын яамны Захиргааны өөрчлөлт шинэчлэлт, иргэдийн өргөдөл, гомдол хариуцсан хэлтэс (*Department of Administrative Reforms and Public Grievances, Ministry of Personnel, Public Grievances & Pensions*) болно.

2007 онд Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хяналтын цахим систем (*Centralised Public Grievance Redress and Monitoring System*) байгуулагдсан байна. Энэтхэгийн Засгийн газраас иргэдийн өргөдөл, гомдол шийдвэрлэх нэгдсэн портал сайт (*Portal for Public Grievances 131106*), Олон нийтийн гомдлыг барагдуулах хяналтын

төвлөрсөн систем 5.0 (*Centralized Public Grievance Redress And Monitoring System (CPGRAMS) version 5.0*) программ ашигладаг байна.

Одоогийн байдлаар бүх яам, тэдгээрийн харьяа төрийн захиргааны 6000 гаруй байгууллага энэ системд холбогдон ажиллаж байна. Иргэд энэ системд холбогдсоноор өргөдөл, гомдлоо аль нэг төрийн байгууллагад цахимаар илгээх боломжтой болжээ. Гэвч төрийн байгууллагууд иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх дотоод журам болон дотооддоо баталсан “Иргэний эрхийн тунхаг бичиг” (*Citizens’ Charter*)-ийг баримтлан ажиллах нь ховор, үүнээс шалтгаалан иргэд, олон нийт хохирч үлдэх нь элбэг тул иргэдийн өргөдөл, гомдлыг нэгдсэн нэг хуулиар зохицуулах шаардлага тулгарчээ.

Иймээс 2011 онд Хүний нөөц, тэтгэвэр тэтгэмж, өргөдөл, гомдлын яамны сайд Төрөөс үзүүлэх үйлчилгээ болон өргөдөл, гомдолд тогтсон хугацаанд хариу авах иргэний эрхийн тухай (*The right of citizens for time bound delivery of goods and services and redressal of their grievances bill*) хуулиар төрийн захиргааны байгууллага бүр “Иргэний эрхийн тунхаг бичиг” (*Citizens’ charter*)-ийг батлах шаардлагатай хийгээд уг тунхаг бичигт иргэн аливаа төрийн байгууллагатай харилцахад байгууллагын хүлээх үүрэг хариуцлага, иргэний эдлэх эрхийг тодорхой заах ба тодруулбал, төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээ нь тогтсон хугацаатай байх, түүнчлэн үүний дагуу иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдол, санал хүсэлтийг тогтсон хугацаанд шийдвэрлэх гэх мэт иргэд, төрийн байгууллага хоорондын харилцаанд гарах асуудлыг зохицуулахаар заажээ.

Иргэдийн өргөдөл, гомдол бүрийг “Олон нийтийн гомдол барагдуулах хяналтын төвлөрсөн систем (CPGRAMS)” программд хүлээн авсан санал, гомдлын талаар нарийвчилсан мэдээллийг мэдээллийн санд байршуулах, түүнчлэн бусад байгууллагатай мэдээлэл солилцох, байгууллагуудын хооронд хүлээгдэж байгаа санал, гомдлыг шалгах, дүн шинжилгээ хийх, статистик мэдээллийг шуурхай боловсруулах боломжтой байдаг байна.

Австрали Улс

Австрали Улсын иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, Парламентын өмнө гомдлоо шууд илэрхийлэн гаргах эрх нь нээлттэй байдаг байна. Өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааг Төрийн албаны тухай хууль (*Public service act*)⁵³, Австралийн Засгийн газар, Төрийн албаны комиссын 2006 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн №13/06 дугаартай тогтоол⁵⁴, Австралийн ISO 10002-2006 стандартыг⁵⁵ баримтлан шийдвэрлэдэг. Уг тогтоолоор алба, агентлагуудад өргөдөл, гомдлын менежментийн тогтолцоо бий болгон, тэдгээр тогтолцооны үндсэн стандартыг тогтоожээ.⁵⁶

Дээрх тогтоолд “Агентлаг” гэдгийг төрийн албан байгууллага гэж ойлгох ба “өргөдөл, гомдол” бол тухайн нэг агентлагийн эсвэл түүний албан хаагчийн тухай сэтгэл хангалуун бус байдлаа аман эсвэл бичгийн хэлбэрээр гаргасан илэрхийллийн ерөнхий нэр томъёо бөгөөд “Өргөдөл, гомдлын менежментийн тогтолцоо” гэдэг нь өргөдөл гомдлыг хүлээн авч, бүртгэн, хариу өгч, тайлагнаж буй агентлагийн хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа ба хэрэглэж буй хүний нөөц, технологи юм гэж тодорхойлжээ.⁵⁷

Өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн систем байхгүй хэдий ч дээрх тогтоолоор бүх агентлаг нь өргөдөл, гомдлын менежментийн ямар нэг тогтолцоо бий болгон хэрэглэх ёстой бөгөөд аливаа агентлагийн өргөдөл, гомдлын менежментийн тогтолцоо нь бичиж боловсруулсан бодлого ба үйл ажиллагаа бүхий байхыг шаарддаг байна. Мөн өргөдөл, гомдлын

⁵³ Public Service Act, 2008. <https://www.legislation.qld.gov.au/LEGISLTN/CURRENT/P/PublicServA08.pdf>

⁵⁴ http://www.health.qld.gov.au/nonconsumer_complaint/docs/OPSC_Directive.pdf-Directive,13/06-ComplaintsManagementSystems.

⁵⁵ Australian Standard™ Customer satisfaction- Guidelines for complaints handling in organizations (ISO 10002:2006). MOD)- <http://www.saiglobal.com/pdftemp/previews/osh/as/as10000/10000/10002-2006.pdf>

⁵⁶ Г.Чулуун нар, Иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх нэгдсэн тогтолцооны талаарх гадаадын зарим орны туршлага (Харьцуулсан судалгаа), Улсын Их Хурлын Тамгын газар, Судалгааны эмхэтгэл, XVIII боть, 246 дахь тал.

⁵⁷ Ibid.

тогтолцоонд энэ тогтоолын 7 дугаар хэсэгт тодорхойлон заасан «Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх тогтолцооны элементүүд» буюу Австрали ба олон улсын стандартуудад үндэслэсэн санал гомдол барагдуулахад баримталдаг Австралийн ISO 10002-2006 стандарт бүхий дараах зарчмуудыг⁵⁸ агуулсан байх ёстой. Тухайлбал:

1. ИЛ ТОД: Хаана, хэрхэн гомдол гаргах тухай мэдээлэл хэрэглэгчид, хувь хүмүүс ба сонирхсон бусад хэнд ч болов сайтар түгээгдэн нийтлэгдсэн байх ёстой.
2. НЭЭЛТТЭЙ: Гомдол гаргасан бүх хүнд гомдлыг нь барагдуулах үйл явц нээлттэй хүртээмжтэй байх. Үүнд үйл явцын тухай мэдээлэл бүрэн нээлттэй, өргөдөл, гомдол гаргах арга зам нь уян хатан байх, тусгайлан тус дэм хэрэгтэй (орчуулагч зэргийг оролцуулаад) гомдол гаргагчдад тусгай зохицуулалт хийлгэх эсвэл дэмжлэг авах боломжтой байх зэрэг багтана.
3. ШУУРХАЙ: Аливаа өргөдөл, гомдлыг хүлээн авсан даруйдаа гомдол гаргагчид хүлээн авснаа мэдэгдэнэ. Өргөдөл, гомдлыг шуурхай дамжуулах болон гомдол барагдуулах явцад гомдол гаргагчтай эелдэг харилцаж өргөдөл, гомдлынх нь талаар гарсан ахиц, явцыг мэдээлж байх ёстой.
4. БОДИТОЙ: Гомдлыг шийдвэрлэн барагдуулах үйл явцын турш гомдол гаргагч бүртэй шударга, бодитой бөгөөд ялгаварлалгүй хандан харилцана.
5. ТӨЛБӨРГҮЙ: Өргөдөл, гомдлыг барагдуулах бүх үйл явцад гомдол гаргагч үнэ төлбөргүй хамрагдана.
6. НУУЦЛАЛТАЙ: Өргөдөл, гомдол гаргагчийн хувийн мэдээлэл нь гагцхүү байгууллага дотор тухайн гомдлыг дамжуулахад хаана хэрэгтэй байна, тэр газарт байх ёстой ба гомдол гаргагч өөрөө түүнийг дэлгэхийг шаардаагүй л бол нууцлалыг чандлан хамгаална.

⁵⁸ Австралийн Стандарт, Хэрэглэгчийн сэтгэл ханамж-Байгууллагууд дахь өргөдөл гомдол шийдвэрлэх заавар (AS ISO 10002-2006).

7. ГОМДЛЫН СУДАЛГАА: Гомдолтой холбогдох бүх нөхцөл байдал ба мэдээллийг судлан тогтооход зохих бүх хүчин чармайлтыг гаргах ёстой.
8. ХЭРЭГЛЭГЧ ТӨВТЭЙ АРГА: Байгууллага нь хэрэглэгч төвтэй арга барилыг хэрэгжүүлэх ёстой ба гомдлын талаар эргэж мэдээлэхдээ нээлттэй, гомдлыг шийдвэрлэх чинхүү зорилго бүхий байгаагаа үйл ажлаараа харуулдаг байх.
9. ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ: Зохих судалгааны дараа байгууллага уг асуудлыг засаж залруулах ба дахин гарахаас нь урьдчилан сэргийлэх гэх мэтээр ямар нэгэн хариу арга хэмжээ авах ёстой. Энэ мэт арга хэмжээг авсан даруйдаа гомдол гаргагчид мэдэгдэнэ.
10. ХАРИУЦЛАГАТАЙ: Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажилтай холбоотой байгууллагын шийдвэр ба үйл ажиллагааг хариуцах, тайлагнах явдал тодорхой цэгцэрсэн эсэхийг байгууллага өөрөө батлан даах ёстой.
11. ЯМАГТ САЙЖРУУЛЖ БАЙХ: Өргөдөл, гомдол барагдуулах үйл явц ба үйлчилгээний чанарыг ямагт сайжруулж байх нь байгууллагын нэгэн зүйл хөдөлбөргүй зорилт байх ёстой.

Австралийн ISO 10002-2006 стандартын дагуу алба, агентлаг бүр өргөдөл, гомдлын менежмент бий болгож ажиллах нь байгууллагын удирдлагуудын үүрэг байдаг байна. Өргөдөл, гомдлын менежментийн шуурхай тогтолцооны элементүүд нь заавал хангах ёстой үндсэн стандартуудыг илэрхийлнэ. Төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагаатай холбоотой гаргасан өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын өргөдөл, гомдлын менежментийн тогтолцоогоор шийдвэрлэж чадаагүй болон хөндлөнгийн шалгалт хийлгэхийг хүсвэл Омбудсменд хандан өргөдөл гаргах боломжтой.⁵⁹

⁵⁹ Г.Чулуун нар, Иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх нэгдсэн тогтолцооны талаарх гадаадын зарим орны туршлага (Харьцуулсан судалгаа), Улсын Их Хурлын Тамгын газар, Судалгааны эмхэтгэл, XVIII боть.

Канад Улс

Канад Улсад хууль тогтоох дээд байгууллага болох Парламент болон Засгийн газар, харьяа яам, агентлаг зэрэг төрийн захиргааны байгууллагад хандсан иргэдийн бүх төрлийн өргөдөл, хүсэлт гаргах үйл явц нь 2003 он хүртэл хууль тогтоох дээд байгууллагад хандан хаяглагдаж ирдэг байсан бол 2003 оноос хойш тэдгээрийг Парламент болон Засгийн газар, Засгийн газрын тодорхой салбар хариуцсан яам, сайд, түүнчлэн Парламентын гишүүнд дангаар хаяглан ирүүлдэг болсон байна.⁶⁰

1867-1986 оны хооронд иргэд дангаараа Парламентын Нийтийн танхимд хандан өргөдөл, хүсэлт гаргах боломжтой байсан ба энэ нь 1986 онд батлагдсан Парламентын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөгдөн, Нийтийн танхимаар хэлэлцүүлэх өргөдөл нь хамгийн багадаа 25 хүний гарын үсэгтэй байхаар заажээ.⁶¹

Өргөдлийг хүлээн авсан гишүүн Нийтийн танхимын хуралдаан дээр 15 минутаас илүүгүй хугацаанд танилцуулна. Танилцуулсны дараа өргөдөл, хүсэлт хариуцсан ажилтан өргөдлийг Өргөдөл, гомдол хариуцсан зөвлөл (Privy council)-д шилжүүлнэ. Зөвлөл тухайн өргөдөлд дурдсан асуудлыг шийдүүлэхээр хамаарах яам болон агентлагт тус өргөдлийг шилжүүлнэ. Өргөдөл хүлээн авсан яам болон агентлаг асуудалтай танилцаад өргөдлийн хариуг ажлын 45 өдөрт багтаан Нийтийн танхимд мэдэгдэнэ.

Гэсэн хэдий ч уг заасан хугацаа нь ихэнх тохиолдолд мөрдөгдөхгүй байсан учир 2003 оноос дээрх тогтоосон хугацаанд асуудлыг хамаарах яам болон агентлагаас хариу шийдвэр ирээгүй тохиолдолд өргөдлийн асуудлыг хамаарах Нийтийн танхимын Байнгын хороонд мэдэгдэн, Байнгын хорооны дарга ажлын таван өдрийн дотор Байнгын хорооны хуралдааныг зарлаж тухайн яам болон агентлагийн хугацаа хэтрүүлэх болсон шалтгааныг авч хэлэлцэнэ хэмээн Парламентын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 8(б)-д өөрчлөлт оруулжээ.

⁶⁰ Ibid.

⁶¹ Ibid.

1997 оноос Канад Улсын Засгийн газраас төрийн байгууллагын “Үйлчилгээний жишиг” (Service standard initiative) хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. Энэхүү хөтөлбөрт байгууллага бүр иргэдэд үзүүлж буй үйлчилгээгээ сайжруулахын тулд иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдлыг барагдуулах тогтолцоотой байх шаардлагатай хэмээн заажээ.⁶²

Энэхүү хөтөлбөр батлагдсанаас хойш төрийн байгууллагууд иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмууд баталсаар ирсэн хэдий ч өнөөг хүртэл хууль эрх зүйн нэгдсэн нэг актгүй байна. Төрийн байгууллагууд иргэдэд үзүүлж буй үйлчилгээндээ хэд хэдэн зүйлийг голлон анхаарах ёстой бөгөөд үүний нэг нь төрийн байгууллага болоод түүний үйлчилгээний талаар гаргасан иргэний өргөдөл, гомдлыг түргэн шуурхай барагдуулах гэж заажээ.⁶³

Иргэд Засгийн газрын харьяа аль нэг төрийн байгууллагын үйлчилгээ, үйлчилгээ үзүүлж буй төрийн албан хаагчийн талаар гомдол гаргах эрхтэй. Иргэд гомдлоо тухайн төрийн байгууллагад хандан гаргаснаар тус байгууллага дотоод журмынхаа дагуу иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, үзүүлж буй төрийн үйлчилгээ нь сайжрах боломжтой болно.

Иргэд Засгийн газар, харьяа яамд, агентлагуудад хандан иргэдэд үзүүлж буй үйлчилгээ болон тухайн үйлчилгээ үзүүлж буй төрийн албан хаагчийн талаарх гомдлоо цахимаар Засгийн газрын үндсэн цахим хуудас руу болон түүнд байрлуулсан харьяа яамдын цахим хуудасны “Иргэдийн өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх” гэсэн нүүрэнд, түүнчлэн шуудангаар, утсаар, факсаар ирүүлэх боломжтой.⁶⁴

Холбооны Засгийн газраас төрийн байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэх дүрэм, журмуудын зорилго

⁶² Ibid.

⁶³ Ibid.

⁶⁴ Ibid.

нь Гомдлын менежментийн системийн (*The complaint management system*) зарчимд суурилсан байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс

Бүгд Найрамдах Солонгос Улс нь Иргэдийн өргөдлийг зохицуулах хуулиар (*Civil Petitions Treatment Act*)⁶⁵ хэрэггүй иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх харилцааг зохицуулдаг. Тус хууль 2015 онд батлагдан ба 2017 онд нэмэлт, өөрчлөлт орж байсан аж.

Чех Улс

Чех Улс нь 2001 онд батлагдсан Гомдол хүлээн авах, шийдвэрлэх тухай хуулиар (*Zákon o přijímání a vyřizování stížností*)⁶⁶ иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх харилцааг зохицуулдаг байна. Тус хууль батлагдахаас өмнө Засгийн газрын 150/1958 дугаар тогтоолоор иргэдээс ирүүлсэн гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг байжээ.

Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улс 2006 онд батлагдсан Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын тухай хуулиар (*О порядке рассмотрения обращений граждан Российской Федерации*)⁶⁷ иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэдэг.

Португал Улс

Португал Улс нь иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх тусгайлсан хуульгүй. Ямар эрх нь зөрчигдөж, хэнд хандаж гомдол гаргахаас хамааран ялгаатай зохицуулалт үйлчилдэг. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, эс үйлдэхүйтэй холбоотой

⁶⁵ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47142&lang=ENG&fbclid=IwAR2ta-5ap1NrhkfyXjdEYkrtYkwOC70EspBDqRGtzJGxXqCYtL3yfy1y7GgE

⁶⁶ https://www.senat.cz/xqw/xervlet/pssenat/webNahled?id_doc=1288&id_var=1288

⁶⁷ https://legalacts.ru/doc/59_FZ-o-porjadke-rassmotrenija-obravenij-grazhdan-rossijskoj-federacii/

гомдол гаргах бол Португалийн Омбудсмений дүрмийн⁶⁸ дагуу Омбудсменд, ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг 2006 оны 46 дугаар хуулийн дагуу Нөхөн сэргээх үндэсний байгууллагад гаргадаг байна.⁶⁹

Европын холбоо

Европын холбооны бүх улс төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зорилготой Омбудсмен (*ombudsman*) гэх албан тушаал томилсон байдаг. Омбудсмен нь гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг хянах захиргааны хуулийн нэг хэсэг юм. Европын Омбудсмений алба 1992 онд Маастрихтын хэлэлцээрээр⁷⁰ байгуулагдсан бөгөөд үйл ажиллагааны зорилго нь Европын холбооны иргэн болон оршин сууж амьдардаг хүмүүсээс гаргасан Европын холбооны төрийн байгууллага, институцийн буруу удирдлагын талаарх гомдлыг шалгах явдал юм. “Буруу удирдлага” гэдэг нь муу удирдлага гэсэн үг бөгөөд энэ нь дараах зүйлсийг үл хүндэтгэсэнээр илэрдэг:

- Хууль эсвэл дүрэм;
- Сайн удирдлагын зарчим;

Харин муу удирдлагын зарим жишээг дурдвал ялгаварлан гадуурхах, эрх мэдлээ урвуулан ашиглах, мэдээлэл өгөхөөс татгалзах эсвэл дутуу мэдээлэл өгөх, шаардлагагүй саатал үүсгэх гэх мэт.

⁶⁸ https://www.legislationline.org/download/id/4115/file/PortugueseOmbudsman_Statute_2007_en.pdf

⁶⁹ <https://eportugal.gov.pt/en/cidadaos/cuidador-informal/elogios-reclamacoes-ou-sugestoes>

⁷⁰ <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex%3A11992M%2FTXT>

ХАВСРАЛТ 2. АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРҮҮДИЙН ЖАГСААЛТ

1. 2016 оны 08 сарын 02-ны өдрийн 553 дугаар шийдвэр.
https://shuukh.mn/single_case/1514?daterange=2016-01-01%20-%202017-01-16&id=1&court_cat=3&bb=1

2. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2016 оны 10 сарын 18-ны өдөр, дугаар 791.
https://shuukh.mn/single_case/2057?daterange=2016-01-01%20-%202017-01-16&id=1&court_cat=3&bb=1

3. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2017 оны 01 сарын 11-ний өдөр, дугаар 31.
https://shuukh.mn/single_case/2057?daterange=2016-01-01%20-%202017-01-16&id=1&court_cat=3&bb=1

4. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2017 оны 12 сарын 21-ний өдөр, дугаар 962.
https://shuukh.mn/single_case/4148?daterange=2017-01-01%20-%202018-01-16&id=1&court_cat=3&bb=1

5. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2017 оны 10 сарын 19-ний өдөр, дугаар 757.
https://shuukh.mn/single_case/3987?daterange=2017-01-01%20-%202018-01-16&id=1&court_cat=3&bb=1

6. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2018 оны 01 сарын 30-ны өдөр, дугаар 69.
https://shuukh.mn/single_case/4323?daterange=2018-01-01%20-%202019-01-16&id=1&court_cat=3&bb=1

7. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2018 оны 07 сарын 04-ний өдөр, дугаар 431.
https://shuukh.mn/single_case/5050?daterange=2018-01-01%20-%202019-01-16&id=1&court_cat=3&bb=1

8. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2019 оны 02 сарын 28-ны өдөр, дугаар 134.

https://shuukh.mn/single_case/5894?daterange=2010-01-01%20-%202020-01-16&id=1&court_cat=3&bb=1

9. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2019 оны 05 сарын 15-ны өдөр, дугаар 297. https://shuukh.mn/single_case/5903?daterange=2010-01-01%20-%202020-01-16&id=1&court_cat=3&bb=1

10. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2019 оны 05 сарын 21-ний өдөр, дугаар 308. https://shuukh.mn/single_case/6920?daterange=2010-01-01%20-%202020-01-16&id=1&court_cat=3&bb=1

11. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2019 оны 05 сарын 24-ний өдөр, дугаар 316. https://shuukh.mn/single_case/6102?daterange=2010-01-01%20-%202020-01-16&id=1&court_cat=3&bb=1

12. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2019 оны 07 сарын 23-ны өдөр, дугаар 451. https://shuukh.mn/single_case/7057?daterange=2010-01-01%20-%202020-01-16&id=1&court_cat=3&bb=1

13. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2019 оны 09 сарын 20-ны өдөр, дугаар 0593. https://shuukh.mn/single_case/6662?daterange=2010-01-01%20-%202020-01-16&id=1&court_cat=3&bb=1

14. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2019 оны 11 сарын 25-ны өдөр, дугаар 832. https://shuukh.mn/single_case/6329?daterange=2010-01-01%20-%202020-01-16&id=1&court_cat=3&bb=1

15. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2020 оны 10 сарын 19-ний өдөр, дугаар 128/ППП2020/0659. https://shuukh.mn/single_case/7443?daterange=2020-01-01%20-%202021-01-16&id=1&court_cat=3&bb=1

16. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2020 оны 09 сарын 29-ний өдөр, дугаар 629.

https://shuukh.mn/single_case/7172?daterange=2020-01-01%20-%202021-01-16&id=1&court_cat=3&bb=1

17. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2021 оны 02 сарын 24-ний өдөр, дугаар 128/ШШ2021/0140. https://shuukh.mn/single_case/7843?daterange=2021-01-01%20-%202022-01-16&id=1&court_cat=3&bb=1

18. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2021 оны 04 сарын 01-ний өдөр, дугаар 128/ШШ2021/0249. https://shuukh.mn/single_case/7867?daterange=2021-01-01%20-%202022-01-16&id=1&court_cat=3&bb=1

19. Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2021 оны 04 сарын 19-ний өдөр, дугаар 111/ШШ2021/010. https://shuukh.mn/single_case/7889?daterange=2021-01-01%20-%202022-01-16&id=1&court_cat=3&bb=1

20. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2021 оны 07 сарын 07-ны өдөр, дугаар 128/шш2021/0469. https://shuukh.mn/single_case/8213?daterange=2021-01-01%20-%202022-01-16&id=1&court_cat=3&bb=1

21. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэр, 2021 оны 08 сарын 04-ний өдөр, дугаар 128/ШШ2021/0509. https://shuukh.mn/single_case/8044?daterange=2021-01-01%20-%202022-01-16&id=1&court_cat=3&bb=1

